*Орлого капиталжуулалтын хүүний түвшин, орлого капиталжуулалтын болон мөнгөн гүйлгээний хорогдуулалтын тооцоололын талаарх судалгааны ажлууд байддаг. Харин гарсан үр дүнг нь нягтлан бодох бүртгэлд тусгадаг практик ач холбогдолтой судалгаа одоогоор байхгүй*

**Түлхүүр үг:** хөрөнгийн үнэлгээ, орлогын хандлага, капиталжуулалтын хувь, хорогдуулгын хувь

## **1. УДИРТГАЛ**

Хөрөнгийн үнэлгээний онол арга зүйн тооцооллыг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний практик судалгаанд тулгуурлан үнэлгээний тооцооллыг орлогын хандлагын аргуудаар хийж, үр дүнг СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах нь өгүүллэгийн ажлын зорилго оршино.

Энэхүү өгүүлэл нь хөрөнгийн үнэлгээний орлогын хандлагад ашиглагдах тооцооллуудыг хийж тэдгээрээс сонголт хийсэн тооцоолол, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах арга зүйг хамтад нь бичсэнээр энэхүү өгүүлэлийн шинэлэг тал юм.

Орлогын хандлагын тооцоололд ашиглах параметруудийг эрдэмтэн судлаачид их судалсан байдаг (Барсболд, 2014) (Доржсүрэн, 2003).

Үл хөдлөх хөрөнгийг орлогын хандлагаар үнэлэхэд Орлогын шууд капиталчлах, Мөнгөн гүйлгээг хорогдуулах гэсэн аргаар тооцоолдог. Орлогын хандлагаар үл хөдлөх хөрөнгийг үнэлэхэд мэдээллийн олдоц хангалттай буюу нэгдүгээр түвшний үнийн мэдээлэл ашиглаж байгаа тохиолдолд тооцсон үзүүлэлт бүрээс сонголт хийн үнэлгээний



үр дүнг гаргахдаа ашигладаг. Тухайлбал, мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаар үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тооцоолно, мөн орлогыг шууд капиталчлах аргаар тооцоолол хийн, тооцоолсон дүнгээс эцсийн үр дүнг тооцно.

“Үлэмж” компани нэгэн барилгын санхүүгийн тайлагналын зориулалтаар бодит үнэ цэнийг тооцох шаардлагатай болж дараах мэдээлэлүүд олж авсан.

1. Жил бүр хөрөнгөөс 90,000,000 төгрөгийн цэвэр орлого олохоор боломжтой, 25 жил ашигласан хөрөнгөө үнэлэх шаардлагатай болсон.
2. 500,000.0 мян.төгрөгийн анхны өртөгтэй, 5,000.0 мян.төгрөгийн үлдэх өртөгтэй, 40 жил ашиглагдах барилгыг шулуун шулгамын аргаар элэгдлийг тооцдог. Тухайн хөрөнгийг 5 жилийн дараа 200,000.0 мян.төгрөгөөр худалдах боломжтой.
3. Барилгаас хүртэх хөрөнгө оруулалтын өгөөжийг 10%, газрын өгөөжийг 8 хувь, татварын түвшинг 10%, үл хөдлөх объектод барилгын эзлэх хувийн жин 80% гэж үзсэн,
4. Тухайн барилгын зах зээлийн дундаж өгөөж нь 20%, эрсдлийн коэффициент нь 0.9 байна гэж тооцоолсон. Засгийн газрын бондын жилийн хүү 16% байсан.

Үнэлгээчин мэдээлэлдээ үндэслэн тооцож болох аргууд болох орлогыг шууд капиталчлах, мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаар үл хөдлөх хөрөнгийг үнэлдэг.

Орлогыг шууд капиталчлах аргаар үл хөдлөх хөрөнгийг үнэлэхэд капиталчлах хувийг тооцох хэрэгтэй.

### Нийлбэрийн арга

Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь, нөхөлтийн хувь, татварын хувь гэсэн 3 хувийн нийлбэрээр капиталчлах хувийг тооцдог.

$$\text{Кап. Хувь} = R_{\text{ХО}} + R_{\text{нөхөлт}} + R_{\text{татвар}} \quad (1)$$

Бидний өгөгдөлд  $R_{\text{ХО}}=10\%$ ,  $R_{\text{татвар}}=10\%$ , харин  $R_{\text{нөхөлт}}$ -ийн хувь мэдэгдэхгүй байгаа тул түүнийг тооцох хэрэгтэй. Мэдээлэлд үл хөдлөх хөрөнгийн нөхөлтийн хувийг өгөгдсөн мэдээллээс Рингийн болон Хоскольдын аргаар тооцох боломжтой байна.

А. Рингийн арга

$$R_{\text{Нөхөлт}} = \frac{100\%}{\text{Ашиглалтын хугацаа}} = \frac{100\%}{40} = 2.5\%$$

Б. Хоскольдын арга

$$R_{\text{Нөхөлт}} = \left( \frac{k}{(1+k)^t - 1} \right) = \left( \frac{0.1}{(1+0.1)^{40} - 1} \right) = 0.0023 = 0.23\%$$

Нөхөлтийн хувийг 2 аргаар тооцсон бөгөөд НББ-д элэгдлийг шулуун шулгамын аргаар тооцдог тул үл хөдлөх хөрөнгөөс орж ирэх цэвэр орлого нь цаашид буурна. Ийм учраас Рингийн аргаар тооцсон нөхөлтийн хувийг сонгож авч болно.

$$\text{Кап. Хувь} = R_{\text{ХО}} + R_{\text{нөхөлт}} + R_{\text{татвар}} = 10\% + 2.5\% + 10\% = 22.5\% \text{ болно.}$$

### 1.1 Барилга, газрын өгөөжид үндэслэх арга

Үл хөдлөх хөрөнгөөс олох орлогыг барилга байгууламж болон газраас олох орлого гэж салгах боломжтой тохиолдолд капиталчлах хувийг тооцоолдог арга. Энэ аргаар капиталчлах хувийг тооцож байгаа үед газрын өгөөж, барилгын өгөөжийн хувь болон нөхөлтийн хувийг тус тусад нь тооцоолно. Нөхөлтийн хувийг өмнө сонгож авсан буюу Рингийн аргаа ашигласан.

$$\text{Кап. Хувь} = \beta * (R_{\text{БӨХувь}} + R_{\text{нөхөлт}}) + (1 - \beta)R_{\text{ГазӨХувь}} \quad (2)$$

$$\text{Кап. Хувь} = 0.8 * (0.1_{\text{БӨХувь}} + 0.025) + (1 - 0.8) * 0.08_{\text{ГазӨХувь}} = 11.6\%$$

## 1.2 CAPM загвар буюу капитал хөрөнгийн үнэлгээний загвараар капиталчлах хувийг тооцох

$$\text{Кап. Хувь} = \beta * (R_{\text{ЗЭГөөжХувь}} - R_{\text{Эрсдэлгүй хүүний Хувь}}) + R_{\text{Эрсдэлгүй хүүний Хувь}} \quad (3)$$

$$\text{Кап. Хувь} = 0.8 * (0.20 - 0.16) + 0.16 = 0.032 + 0.16 = 19.2\%$$

Дээрх капиталчлах хувийн тооцоолуудаас капитал хөрөнгийн үнэлгээний загвараар тооцсон капиталчлах хувийг үндэслэлтэй гэж үзэн сонгон үнэлгээнд ашиглахад дараах байдалтай болно.

$$\text{Үнэлгээ} = \frac{\text{ҮАЦОрлого}}{\text{Кап.Хувь}} = \frac{90,000,000}{19.2\%} = 468,750,000 \text{ төгрөг}$$

Хөрөнгийн үнэлгээчин нь дараагын арга болох мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаар үнэлгээг хийж үздэг. Үл хөдлөх хөрөнгөөс олох орлого харилцан адилгүй, хувьсах шинж чанартай бол мөнгөн гүйлгээг хорогдуулах аргыг ашиглах нь давуу талтай.

Үл хөдлөх хөрөнгийг эзэмших хугацааны үйл ажилагааны үе тутамд олох орлого болон хугацааны эцэст хөрөнгийг худалдснаас олох орлогыг өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэх замаар үнэлгээг дараах дараалалаар тооцно. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгөөс олох урсгал орлого буюу үйл ажиллагааны цэвэр орлогын өнөөгийн үнэ цэнэ.  $/PV_1/$
2. Үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүнийг худалдсанаас олох цэвэр орлогын өнөөгийн үнэ цэнэ.  $/PV_2/$
3. Зээлийн үндсэн өрийн үлдэгдлийн өнөөгийн үнэ цэнэ.  $/PV_3/$

$$\text{Үнэлгээ} = PV_1 + PV_2 + PV_3 \quad (4)$$

Бидний тооцоололд зээлийн үлдэгдэл өгөгдөөгүй тул хөрөнгийг худалдан авахдаа өөрийн хөрөнгөөр худалдан авсан гэж үзнэ.

Үл хөдлөх хөрөнгийг ашиглалтын хугацааны эцэст борлуулах бол үндсэн томъёо дараах байдалтай болно.

$$PV = \sum_{n=1}^T CF_t * \frac{1}{(1+r)^t} + \frac{\text{Худалдсан цэвэр орлого}}{(1+r)^t}$$

*Хүснэгт 1. Мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаарх үнэлгээний тооцоолол.*

Үзүүлэлт	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил
Цэвэр орлого	90,000,000	90,000,000	90,000,000	90,000,000	90,000,000
Элэгдлийн зардал	12,375,000	12,375,000	12,375,000	12,375,000	12,375,000
Мөнгөн урсгал	102,375,000	102,375,000	102,375,000	102,375,000	102,375,000

Өнөөгийн үнэ цэнийн коэффициент	0.8389	0.7038	0.5904	0.4953	0.4155
Мөнгөн урсгалын ӨҮЦ	85,885,067	72,051,231	60,445,663	50,709,449	42,541,484
<b>5 жилийн хорогдуулсан мөнгөн урсгалын нийлбэр</b>					<b>311,632,895</b>
5 жилийн дараах борлуулалтын үнэ					200,000,000
5 жилийн дараах борлуулалтын ӨҮЦ					<b>83,109,127</b>
<b>Хорогдуулсан мөнгөн гүйлгээний дүн</b>					<b><u>394,742,021</u></b>

Хорогдуулгын хүүгийн түвшинг 19.2% гэж тооцон ашигласан. Орлогын хандлагад багтдаг хоёр аргаар үнэлгээг тооцоолсоны үндсэн дээр үнэлгээчин өөрийн хийсэн тооцоолол, судалгаа, мэдээлэлдээ үндэслэн нэг аргыг нь сонгодог. Дээрх тооцоололоос мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаар тооцсон үнэлгээг үндэслэлтэй гэж үзэж болно.

Дээрх тооцооллын дүнд үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний өдрөөрх бодит үнэ цэнийг бүхэлчлэн **394,742,000 (гурван зуун ерэн дөрвөн сая долоон зуун дөчин хоёр мянган төгрөг) төгрөг** гэж тооцлоо.

Дахин үнэлэгдсэн хөрөнгийн үнэлгээг ҮОУС-2017 -д зааснаар үнэлгээний өртгийн, орлогын, зах зээлийн жишиг үнийн гэсэн хандлагуудын тохиромжтой аргуудаар тооцсон үнэлгээнээс хамгийн үндэслэлтэйг сонгон авч НББ-д тусгах болон холбогдох шийдвэр гаргахдаа ашиглана.

Үндсэн хөрөнгийн дараа үеийн хэмжилтийг ЖДААНОУС 16, НББОУС 16 , УСНББОУС 17 зэрэгт зааж харуулсан байдаг.

Газар, барилга байгууламжийн бодит үнэ цэнийг мэргэжлийн үнэлгээчний тодорхойлдог тооцоолол, зах зээлийн нотолгоонд суурилсан хөрөнгийн үнэлгээгээр тогтоодог. Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэн гэдэг нь ихэвчлэн үнэлгээгээр тогтоосон зах зээлийн үнэ байна.

#### **Өртгийн загвар**

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлэх ёстой (International Federation of Accountants, 2011).

#### **Дахин үнэлгээний загвар**

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байх шаардлагатай. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт дахин үнэлгээг хийх шаардлагатай (International Federation of Accountants, 2011)

Хэрэв үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол дахин үнэлгээний өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг дор дурдсан аргын аль нэгээр бүртгэнэ (International Federation of Accountants, 2011)

- а. Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны нийт үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлж дахин тооцох ба ингэснээр дахин үнэлгээний дараах хөрөнгийн дансны үнэ нь дахин үнэлсэн дүнтэй тэнцүү болно. Энэ аргыг ихэвчлэн элэгдүүлсэн орлуулалтын өртгөөс индексийн тусламжтайгаар хөрөнгийг дахин үнэлэх үед хэрэглэдэг

- b. Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны нийт үнээс хасах ба гарсан цэвэр дүнг хөрөнгийн дахин үнэлсэн дүн гарах хүртэл тооцно. Энэ аргыг ихэвчлэн барилга, байгууламжид хэрэглэдэг. Хуримтлагдсан элэгдлийг дахин тооцох эсвэл устгахад үүсэх тохируулгын дүн нь дансны үнийн өсөлт, бууралтын хэсэг нь болно.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн бол уг өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Өмнө дахин үнэлсний үр дүнд бууралт үүсч байсан бөгөөд түүнийг тухайн хугацаанд алдагдлаар бүртгэсэн хөрөнгө нь дараагийн дахин үнэлгээгээр бодит үнэ цэн өссөн тохиолдолд тухайн алдагдлын хэмжээтэй тэнцүү хэмжээний өсөлтийг нь тайлант хугацааны ашгаар хүлээн зөвшөөрч, түүнээс давсан хэсгийг дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэнэ (International Federation of Accountants, 2011).

Анхны дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол уг бууралтыг тайлант хугацааны алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Мөн өмнө нь дахин үнэлгээний үр дүнд өсөлт үүссэн бөгөөд дараагийн дахин үнэлгээгээр бууралт үүссэн бол өмнөх дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг тэг болтол бууруулж бичих бөгөөд түүнээс давсан дүнг тайлант хугацааны алдагдлаар бүртгэнэ (International Federation of Accountants, 2011).

“Үлэмж” компаний 500.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, 309,735.0 мянган төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй, 190,265.0 мянган төгрөгний дансны үнэтэй, 25 жил ашигласан барилгаа дахин үнэлж үнэлгээний үр дүнг бүртгэхээр болсон. Барилгыг орлогын хандлагаар дахин үнэлэхэд 394,742.0 мянган төгрөг гэж үзэн цааш ашиглах жилийг 20 жил хэмээн тооцсон байна.

Үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг өмнөх 2 аргаар тооцоолсоны хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаарх тооцооллыг үнэлгээчин илүү үр дүнтэй гэж үзсэн тул бодит үнэ цэн нь 394,742.0 мянган төгрөг гэж тооцсон. Өөрөөр хэлбэл, 190,265.0 мянган төгрөгний дансны үнэтэй хөрөнгийг дахин үнэлсэний үр дүнд 394,742.0 мян.төгрөгөөр бүртгэх боломжтой.

Хуримтлагдсан элэгдлийг хувь тэнцүүлэн бүртгэх арга:

Үлдэгдэл өртөг 190,265.0 м.т-өөс 394,742.0 м.төг хүртэл буюу 2.0747 дахин өссөн.

Дт. Үндсэн хөрөнгө 537,350.0 /500,000.0\*2.0747-500,000.0/

Кт. Хуримтлагдсан элэгдэл 332,873.0

/309,735.0\*2.0747-309,735.0/

Кт. Дахин үнэлгээний нэмэгдэл 204,477.0 /394,742.0-190,265.0/

Дахин үнэлэгдсэн хуримтлагдсан элэгдлийг хувь тэнцүүлэн бүртгэж байгаа тохиолдолд үнэлсэн бүрэн орлуулалтын өртөг нь анхны өртөг болохгүй, үнэлгээнд тооцоолсон хуримтлагдсан элэгдэл нь бүртгэлд тусгах хуримтлагдсан элэгдэл шууд болохгүй юм. Харин үнэлэгдсэн дансны үнэ нь дахин үнэлэгдсэн дүнтэй тэнцүү байх ёстой.

Хуримтлагдсан элэгдлийг тэг болтол бууруулж бүртгэх арга:

Дт. Хуримтлагдсан элэгдэл 309,735.0

Кт. Үндсэн хөрөнгө 309,735.0

Дт. Үндсэн хөрөнгө 204,477.0

Кт. Дахин үнэлгээний нэмэгдэл 204,477.0

Энэхүү бичилтүүд нь өмнөх дахин үнэлгээгээр өссөн буурсан тохиолдлыг харгалзан үзэж, дэлгэрэнгүй орлогын тайлангаар дэмжин эздийн өмчийн хэсэгт тусгагдана.

## 2. ДҮГНЭЛТ

Үнэлгээчид, аудиторуд, эрдэмтэн багш нар орлого капиталжуулалтын хүүний түвшин, орлого капиталжуулалтын болон мөнгөн гүйлгээний хорогдуулалтын тооцоололын талаарх судалгааны ажлууд их. Харин үнэлгээний үр дүнг нь нягтлан бодох бүртгэлд тусгадаг практик ач холбогдолтой судалгаа, нийтлэл одоогоор байхгүй. Харин хөрөнгөө санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлсэн үнэлгээг аудитын компаниас зөвөлгөө өгч нягтлан бодох бүртгэлийн бичилт хийдэг байгууллагууд олон байдаг. Ийм учраас дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөрөнгийг үнэлэхэд үнэлгээчин боломжит бүх судалгаа, тооцоолол хийж байх,
2. Тооцоолсон үнэ цэнүүдийг хамгийн зөв, үндэслэлтэй гэснийг сонгож сурах,
3. Үнэлгээний үр дүнг нягтлан бодох бүртгэлдээ тусгах ойлголттой байх

Энэхүү практик ач холбогдолтой судалгааг санхүүгийн тайлангаа үнэлүүлсэн, нягтлан бодох бүртгэлд бүртгэж чадахгүй, мөн үнэлгээний тайлангын хэрэглэгчдийн ихэнх нь СТОУС болон ҮОУС-ын уялдаа холбоог ойлгох хэрэгтэй юм.

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Аудитын олон улсын стандарт. In Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институт, *A353* (р. 30). Нью-Йорк. International Federation of Accountants. (2011). Аудитын олон улсын стандарт. In Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институт, *A354* (р. 35). Нью-Йорк.
2. International Federation of Accountants. (2011). Аудитын олон улсын стандарт. In Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институт, *A354* (р. 39). Нью-Йорк.
3. International Federation of Accountants. (2011). Аудитын олон улсын стандарт. In Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институт, *A354* (р. 40). Нью-Йорк.
4. International Federation of Accountants. (2011). Аудитын олон улсын стандарт. In Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институт, *A353* (р. 31). Нью-Йорк.
5. Барсболд, Д. (2014). “Бизнесийн үнэлгээний хорогдуулах хүүний шинжилгээ, таамаглал”. *Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Диссертаци.*
6. Доржсүрэн, С. (2003). "Бизнесийн байгууллагын үнэ цэнийг орлогоор хэмжих, удирдах онол арга зүйн зарим асуудал". *Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, Диссертаци., Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Удирдлагын академ.*
7. Понукалин Александр Владимирович. (2012). Экономика недвижимости, *Учебное пособие*
8. International Accounting Standart Boar. (2011). Санхүүгийн тайланалын олон улсын стандартууд

Товчилсон үгийн тайлбар:

1. ҮОУС –Үнэлгээний олон улсын стандарт
2. СТОУТ- Санхүүгийн тайлагнылын олон улсын стандарт
3. ЖДААНОУС – Жижиг дунд аж ахуйн нэгжийн олон улсын стандарт
4. НББОУС- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
5. УСНББОУС – Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

## МОНГОЛ УЛСЫН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨГЖИЛД ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

**О.Хишигмөнх<sup>1,a</sup> (докторант)**

<sup>1</sup>Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн нийтийн  
эрх зүйн тэнхимийн багш

<sup>a</sup>khishigmunkh@otgontenger.edu.mn

### **Хураангуй**

*Дэлхийн эдийн засаг дахь өрсөлдөөн улам бүр нэмэгдэж бараа бүтээгдхүүний үнээс илүүтэй чанар, шинэлэг байдал, шинжлэх ухааны ололт амжилтыг шингээсэн байдал нь хэрэглэгчдийн татах чухал хүчин зүйлс болсон бөгөөд өрсөлдөөн дундаас ашиг олох гэсэн тэмцэл улам бүр ширүүссээр байна. Монгол Улс ч гэсэн энэхүү өрсөлдөөн дундаас ангид байх боломжгүй учир өөрийн давуу тал, нөөц баялагтаа тулгуурлан хөгжих гарцыг хайж олон тулгуурт эдийн засгийг бий болгох ирээдүйдээ үлдээх нөөцийг бодолцон тогтвортой хөгжихийг эрмэлзсээр байна. Үүний нэг нь чөлөөт бүсийг хөгжүүлэх замаар орон нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих явдал юм. Орчин үед дэлхийн чөлөөт бүсүүд чөлөөт боомтоос шинжлэх ухаан, технологи-үйлдвэрлэлийн төв болон өөрчлөгдөн байгаа үед Монгол Улсын чөлөөт бүсийн хөгжил, эдийн засаг оруулах хувь нэмэр, эрх зүйн зохицуулалт болон хөрөнгө оруулалтын үр дүнг бодит байдалтай харьцуулан шинжлэх замаар асуудлыг хөндөхийг зорьсон болно.*

**Түлхүүр үг:** эдийн засаг, хөрөнгө оруулалт, экспорт, татвар, ажлын байр

## **ОРШИЛ**

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай”<sup>1</sup> үзэл баримтлалыг 1995 онд баталж чөлөөт бүс байгуулах үндэслэл, шаардлага, онцлог зарчим, угтвар нөхцөл, баримтлах шалгуур үзүүлэлтийг тодорхойлон өдгөө хүртэл гурван чөлөөт бүс байгуулахаар хууль батлан тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн боловч бодит байдал дээр чөлөөт бүсээ жинхэнэ утгаар байгуулж чадаагүй байна. Чөлөөт бүсийг газар зүйн хувьд оновчтой байршилд байгуулан гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тухайн улс эдийн засгийн олон талын үр ашгийг хүртдэг. Чөлөөт бүсийг амжилтай хөгжүүлж чадсан улсуудын ихэнх нь далайн боомт болон бусад улстай хил залгаа эдийн засгийн ач холбогдолтой цэгийг сонгон байгуулдаг. Монгол Улсын хувьд газар зүйн байрлалын хувьд хоёр улстай хиллэдэг, далайд гарцгүй зэрэг онцлогоо харгалзан Оросын Холбооны улстай хиллэдэг Алтанбулаг болон Цагааннуур боомт, Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэдэг Замын Үүд боомтонд тулгуурлан чөлөөт бүс байгуулсан. Чөлөөт бүсийн үйл ажиллагаа амжилтай явагдахад төрийн бодлого, орон нутгийн оролцоо, бизнес эрхлэгч буюу хөрөнгө оруулагчийн дэмжлэг маш чухал тулгуур хүчин зүйл болдог бөгөөд Монгол Улсын хувьд өнөөг хүртэл хөгжүүлэхээр зорьсон 20 гаруй жилийн туршид ахиц гараагүй шалтгааныг олон талаас судлах шаардлага зайлшгүй байна.

### **1. ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Чөлөөт бүсийн анхны хэлбэр нь XV дугаар зуунд Европ тивд эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдснаар үүссэн гэж судлаачид үздэг. Дэлхийн хоёрдугаар дайны дараа улсууд чөлөөт бүсийг олон хэлбэрээр богино хугацаанд байгуулан амжилт олсон нь цаашдаа улсуудыг чөлөөт бүс байгуулах, дэлхийн худалдааны эргэлтээс ашиг хүртэх замыг нээж өгсөн. Нэгдсэн Үндэстний байгууллагын үндсэн байгууллага болох Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөл нь 1967 онд чөлөөт бүсийг хөгжиж буй орнуудын экспортыг хөгжүүлэх арга барил болохыг хүлээн зөвшөөрснөөр улсууд эдийн засгийн эргэлтээ сайжруулах зорилгоор чөлөөт бүс байгуулан гааль, татварын бодлогоо уян хатан болгох, харилцан ашигтай худалдаа хийх боломж бүрдсэн.

Япон Улсын Киото хотноо 1973 онд “Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай” олон улсын конвенц батлагдан уг конвенцид “Чөлөөт бүс нь нэг улсын нутаг дэвсгэрийн тодорхой нэг хэсэг бөгөөд тэнд оруулсан бараа, бүтээгдэхүүн нь тухайн улсын нутаг дэвсгэрийн гадна байгаа гэж тооцогдож импортын татвар, гаалийн энгийн шалгалтаас чөлөөлөгдөнө”<sup>2</sup> гэж заасан бол Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хуульд чөлөөт бүс” гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг<sup>3</sup> хэлнэ хэмээн тодорхойлжээ. Харин орчин үед чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын онцлогыг харгалзан тухайн орны бусад хэсэгт үл хэрэглэгдэх хөнгөлөлт,

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоол

<sup>2</sup> Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай конвенц 1973 онд батлагдсан, Монгол Улс 2006 онд нэгдэн орсон.

<sup>3</sup> Чөлөөт бүсийн тухай хууль (2015) 3.1.1

урамшууллын онцгой дэглэм бүхий үндэсний эдийн засгийн орон зайн хэсэг гэж үздэг болсон.

Чөлөөт бүсийг улсууд хөгжлийн түвшингээсээ хамаарч өөр өөр зорилгоор байгуулдаг бөгөөд хөгжингүй улсууд гадаад эдийн засгийн харилцаагаа идэвхжүүлэх, улс хоорондын хөгжлийн ялгааг арилгах бодлого хэрэгжүүлэх, жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг сэргээх, худалдааг дэмжих, худалдааны зардлыг бууруулахаар байгуулдаг бол хөгжиж байгаа улсууд дэд бүтцийг бий болгох, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, улсын эдийн засгийг сайжруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилгоор, харин буурай хөгжилтэй улсууд хөрөнгө оруулалтыг татах, техник, технологийн хоцрогдлыг арилгах, ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд чөлөөт бүсийг байгуулдаг.

Монгол Улсын хувьд дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна, төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна<sup>4</sup> гэж заасны дагуу чөлөөт бүсийн тухай хуулийг батлан байгуулах зорилго, хэрэгцээ, шаардлагыг нь тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх<sup>5</sup> зорилготойгоор байгуулахаар тусгасан. Нийтлэг байдлаараа улсуудын чөлөөт бүсийг байгуулах зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний үйлдвэрлэгчид бизнесийн таатай орчин бүрдүүлэх, экспортоос орлого олох, технологи дамжуулах, бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлөө хурдасгахаар байгуулж байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комиссоос хийсэн судалгаагаар улсуудын засгийн газрын чөлөөт бүс байгуулах үндсэн шалтгаан нь нэгдүгээрт хөрөнгө оруулалтыг татах, хоёрдугаарт ажлын байр нэмэгдүүлэх, гуравдугаарт орлого олох бол чөлөөт бүсэд бизнес эрхлэгчдийн хувьд шийдвэр гаргахдаа анхаардаг гурван гол хүчин зүйл ЗБ буюу нэгд, байршил, хоёрт байршил, гуравт байршил гэсэн дүрэм<sup>6</sup>-ийг баримталдаг болох нь тогтоогдсон байна. Тиймээс бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулах эсэхээ шийдвэрлэхэд зөвхөн байршлаас шалтгаалж хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэх эсэхээ шийдвэрлэдэг нь харагдаж байна.

Чөлөөт бүсийг улсууд олон хэлбэрээр байгуулан ажиллаж байгаа бөгөөд сүүлийн үед аль болох төрийн оролцоог багасгах, үр ашигтай байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн бие даасан хараат бус байдлыг нь бүрдүүлэх зорилгоор төрийн мэдлээс хувьд шилжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Чөлөөт бүсийг хамтын ажиллагааны түвшин, өмчийн хэлбэр, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлээр нь олон хэлбэрээр ангилан үздэг. Хамтын ажиллагааны түвшингээр нь гадаад зах зээлд чиглэсэн, үндэсний зах зээлд чиглэсэн, өмчийн хэлбэрээр нь улсын, хувийн, холимог, үйл ажиллагааны

<sup>4</sup> Монгол Улсын Үндсэн хууль (1992) 5.1, 5.4

<sup>5</sup> Чөлөөт бүсийн тухай хууль (2015) 4.1

<sup>6</sup> Отгонсайхан.Н “Олон улсын бизнес” УБ,(2009) х.378



чиглэлээр нь худалдааны, үйлдвэрлэлийн, технологийн, үйлчилгээний, цогцолбор, зохион байгуулалтаар нь нутаг дэвсгэрийн болон үйл ажиллагааны гэж ангилдаг. Нутаг дэвсгэрийн нь тухайн газар үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж үйл ажиллагааны хөнгөлөлтэй журмыг ашигладаг. Тухайлбал, Цагааннуур чөлөөт бүс, Замын Үүд чөлөөт бүс, Алтанбулаг чөлөөт бүс. Үйл ажиллагааны гэдэг нь холбогдох аж ахуй нэгж эх орныхоо хаана байгаагаас үл хамааран худалдаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааныхаа тодорхой төрөлд хөнгөлөлтэй журам хэрэглэхийг хэлнэ<sup>7</sup> хэмээн тодорхойлжээ. Орчин үед чөлөөт бүсийн төрөл нэмэгдэж аялал жуулчлал, хөдөө аж ахуй, ложистик, мэдээллийн технологийн чиглэлээр бүс байгуулах болсон байна. Монгол Улсад үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор<sup>8</sup> хуульчилсан.

Монгол Улс 1995 онд “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоолоор баталж улмаар 2002 онд Чөлөөт бүсийн тухай хууль, 2002 онд “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, 2003 онд “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд баталсан боловч 2015 онд Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлагдснаар тус тусдаа байсан чөлөөт бүсийн хуулиудыг хүчингүй болгосон. Мөн чөлөөт бүсийн тухай хуулиас гадна гаалийн тухай хууль, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Киотогийн конвенцийн зарим холбогдох заалт, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горимыг хэрэгжүүлэх журам” зэрэг хэм хэмжээгээр чөлөөт бүстэй холбогдох харилцааг зохицуулж байна. Чөлөөт бүсийг амжилттай явуулахад тодорхой нөхцөл бүрдсэн байх шаардлагатай<sup>9</sup> гэж үздэг байна. Үүнд:

- Дундажаас дээгүүр түвшний бизнесийн дэд бүтэц: Газар, оффис, талбай, бизнесийн үйлчилгээ, олон нийтийн үйлчилгээ, ажиллах хүчний нөөц, түүхий эд материал, бусад баялаг

- Бизнесийн уян хатан зохицуулалт: Гаалийн хяналт, шалгалтыг оновчтой зохион байгуулах, хүнд суртал, зардал чирэгдэлгүй байх, нэг цэгийн үйлчилгээтэй, хууль эрхзүйн орчин уян хатан байх

- Оффшор байрлал: Чөлөөт бүсийг аль болох хамгийн бага зардалтайгаар бизнес эрхлэх боломжтой, тээврийн сүлжээ бүхий газар байгуулах нь онцгой ач холбогдолтой

- Экспортод чиглэсэн байх: Чөлөөт бүсэд байгуулагдсан ихэнх үйлдвэрүүдийн үндсэн зорилго нь экспортын зах зээлд гарах явдал байдаг.

- Гадаад хөрөнгө оруулагчдад инсентивийг санал болгох: Хөрөнгө оруулагчдад хөнгөлөлт, урамшууллыг санал болгодог.

Чөлөөт бүсийг байгуулснаар экспортын үйлдвэрлэлийг урамшуулсны үндсэн дээр валютын эх үүсвэртэй болох, ажлын байр нэмэгдэх, үндэсний аж ахуйн өсөлтийг нэмэгдүүлэх, гааль, татвар, хөрөнгө оруулалтын тогтолцоо нь гадаад ба дотоодын хөрөнгө оруулагчдад хамгийн тааламжтай нөхцлийг бий болгодог<sup>10</sup> гэж үздэг байна. Мөн тухайн бүсэд ажлын байр нэмэгдэж, амжиргааны түвшин дээшлэх, гадаад шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх зэрэг эерэг үр дагаварууд илэрдэг бол Засгийн оролцоо шаарддагаас үүдэж улс төрийн нөлөө орох, төрийн бодлого тогтворгүйгээс үүдэж хөрөнгө оруулагч буурах, эхний

<sup>7</sup> Отгонсайхан. Н “Олон улсын бизнес” УБ,(2009) х.381

<sup>8</sup> Чөлөөт бүсийн тухай хууль (2015) 18.1

<sup>9</sup> Отгонсайхан. Н “Олон улсын бизнес” УБ,(2009) х.381

<sup>10</sup> Долгорсүрэн. Ц “Олон улсын худалдаа” УБ, (2017) х.644-645

жилүүдэд бизнесийн таатай орчин бүрдэж орлого орох нь тодорхойгүй байх зэрэг эрсдлүүд тулгардаг.

Улс бүр өөрийн нөөц боломж, онцлог дээрээ тулгуурлан чөлөөт бүсийн төрлөө сонгодог бөгөөд чөлөөт бүсийг байгуулснаар нэн тэргүүнд тухайн бүсэд бизнес эрхлэгч ашигтай ажиллах, иргэд ажлын байртай болох нь чухал асуудал юм. Ингэснээр улсын экспортын барааны нэр төрөл нэмэгдэх, үндэсний үйлдвэрлэгч хөгжих боломж бүрдэх юм. Чөлөөт бүсийг байгуулахад төрөөс бизнесийг дэмжих зорилгоор нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнд суурилсан байх, чөлөөт бүс байрлах бүс нутагт авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой байх, чөлөөт бүсэд ашиглах усны нөөц, эрчим хүчний хангамжтай байх, хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлийг хангасан байх, чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж, байгууллага итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин, нөхцөл бий болгох, байгаль орчинд ээлтэй байх, бүс нутгийн тогтвортой хөгжил, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилтныг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх зарчим, нөхцлийг баримтлах<sup>11</sup> аар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана”<sup>12</sup> гэж тусгасан нь бодлогыг тодорхой, заавал хэрэгжүүлэх ажил гэж үзэн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөсөн боловч одоогоор хуулийн зорилго болон засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна. Магадгүй засгийн газар 2020 он хүртэл үлдсэн хугацаандаа үйл ажиллагааг эхлүүлэх боломж байж болох боловч өнөөгийн улс төрийн байдал, засгийн газрын үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадамжийг харахад бодит ажил хэрэг болох магадлал тун бага байна.

Чөлөөт бүсийг байгуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт, тогтвортой хэрэгжих төрийн зөв бодлого, оролцоо маш чухал үүрэгтэй юм. Эрх зүйн орчныг бүрдүүлэх нь хангалтгүй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх засгийн газрын үүргээ гүйцэтгэх байдлаас хамаарч хөгжлийн тулгуур болох бизнесийн оролцоог хангах явдал төрийн бодлогоос шалтгаалдаг. Тийм ч учраас тухайн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон гаалийн хялбарчилсан горимыг санал болгодог. Тухайлбал чөлөөт бүсийн тухай хуулийг 2015 онд шинэчлэн найруулахдаа эрх зүйн орчныг таатай болгох, зорилгоор зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр, хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй байхаар, барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр, чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөхөөр, чөлөөт бүсэд ажиллаж байгаа хуулийн этгээд өөрийн ажилтныг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцохоор зохицуулсан. Мөн чөлөөт бүсэд татварын цөөнгүй хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхээр тусгасан нь ололтой боловч эрх зүйн зохицуулалтыг үр нөлөөг дүгнэхэд цаг хугацааны хувьд эрт байна.

## **2. ЧӨЛӨӨТ БҮСЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

Монгол Улс бизнесийн үйл ажиллагаа явуулахад бизнес эрхлэлтийн үзүүлэлт бүс нутгийн хэмжээнд нэлээд доогуур байр эзэлсэн нь улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, бизнесийн таатай орчин сайн бүрдэж чадаагүй, тодорхой хэмжээний

<sup>11</sup> Чөлөөт бүсийн тухай хууль (2015) 5.1

<sup>12</sup> Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 дугаар бүлэг.

хүндрэл бэрхшээл байгааг илтгэж байна. Дэлхийн банкны хил дамнасан худалдааны үзүүлэлтээр 2017 онд 103 дугаар байрт жагссан. Тус үзүүлэлт нь тухайн улсын гадаад худалдааны гол хилийн боомтууд дээр худалдааны үйл ажиллагаанд хир хүндрэл гардаг, мөн хилийн худалдааны орчин хир байгааг дүгнэхэд чиглэдэг. 2016 онд 74 дүгээр байрт орж байсан үзүүлэлт Монгол Улс бүс нутгийн хэмжээд хил дамнасан худалдааны үзүүлэлтээр дундаж үзүүлэлттэй байна. Монгол Улсын хууль тогтоомж, хилийн хяналт болон авто зам, төмөр замын дэд бүтэц буюу тээвэр логистикийн бүтцийн хөгжил сул, гааль, мэргэжлийн хяналт, гадаад худалдааны бусад хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хүнд суртал голлох нөлөө үзүүлсэн гэж дүгнэсэн. Тиймээс цаашид чөлөөт бүсийг хөгжүүлэхэд төрийн зүгээс дэд бүтцийг хөгжүүлэх болон байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгч төвтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

Чөлөөт бүсүүдийг байгуулснаас хойш улсын төсвөөс 35 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүний 77 хувийг Алтанбулаг чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан<sup>13</sup> байна. Алтанбулаг чөлөөт бүсийг анх худалдааны чиглэлээр байгуулсан ба 2014 оны 06 дугаар сарын 22 нээгдэн үйл ажиллагаагаа эхэлсэн, одоогоор бүсийн харуул, хамгаалалтын байгууламж, түр цахилгаан хангамж, бүсийн доторх цэвэр, бохир усны шугам хоолой, усан сан, цэвэр усны эх үүсвэрийн шугам хоолой, үерийн хамгаалалтын далан, шалган нэвтрүүлэх байр, гаалийн хяналтын талбай зэрэг нь ашиглалтанд орсон. Алтанбулаг чөлөөт бүсэд бүртгэлтэй нийт 105 аж ахуйн нэгжээс 97 аж ахуйн нэгж газар эзэмшүүлэх болон хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэн байгуулж, хамтран ажиллах гэрээгээр 8 аж ахуйн нэгж бүртгэгдсэн. 2016 онд 16 аж ахуйн нэгжийн газрын төлбөр 24,6 сая төгрөгийг, 2018 оны 09 сарын байдлаар газрын төлбөрийн 25,6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн<sup>14</sup> бөгөөд тухайн бүсэд хэвийн үйл ажиллагаа эрхэлж буй 15 аж ахуй нэгж байна. Энэ нь бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдсэн гэж хэлэхэд асуудалтайг илтгэж судалгаа бөгөөд үйл ажиллагаа явуулах сонирхол аж ахуй нэгжүүдэд байгаа боловч ашиг орлого олох нөхцөл бүрдээгүйг улмаар ажлын байрыг нэмэгдүүлж орон нутгийн хөгжилд томоохон ахиц дэвшил оруулахгүй байгаа нь эдийн засгийн үр өгөөжгүй байдлыг илтгэнэ.

Чөлөөт бүсийг байгуулагдах, үйл ажиллагаа эхлэхэд багагүй цаг хугацаа зарцуулж эдийн засагт өөрийн үүргээ гүйцэтгэхэд дахиад хугацаа хэрэгтэй байгаагаас харахад эдийн засгийн үр ашиг хүртэх, байгуулсан зорилгоо биелүүлэх боломж ойрын хугацаанд бага байна. Энэ нь орон нутгийн хөгжил, төр хувийн хэвшлийн түншлэл болон зах зээлийн хүрээ гэсэн хүчин зүйлтэй салшгүй холбоотой. Орон нутаг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдсан хамгийн түгээмэл бэрхшээл бол бүтээгдхүүнийг худалдан авах, үйлчлүүлэх иргэд буюу зах зээл байхгүйтэй холбоотой. Тиймээс орон нутагт иргэдийг ажиллах, амьдрах боломжийг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтцийг бий болгох, бүсийн нөөц боломжид нь тулгуурлан тодорхой чиглэлүүдээр хөгжүүлэх замаар нийслэлийн төвлөрлийг сааруулах шаардлагатай илтгэж байна. Мөн чөлөөт бүс дэх хөрөнгө оруулалтыг шат дараалан шийдэх, нэг чөлөөт бүсийнхээ хөрөнгө оруулалтыг асуудлыг цогцоор нь төр, хувийн хэвшлийн оролцоотой шийдвэрлэх оновчтой юм. Хөрөнгө оруулалтын үр дүнд бүтээн байгуулалт, үйл ажиллагаа нь өргөжин тэлэх нь ойлгомжтой боловч зарцуулалтыг хянах, богино хугацаанд чөлөөт бүсийг байгуулж үйл ажиллагааг

<sup>13</sup> <http://www.parliament.mn/n/mrxo>

<sup>14</sup> <http://www.altanbulag.gov.mn/500.html> Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн албаны гаргасан ажлын тайлан.

явуулах шаардлага байна. Учир нь өнгөрсөн хугацаанд нэг засгийн газраас нөгөө засгийн газарт эрх мэдэл шилжих явцад зайлшгүй шаардлагатай бүтээн байгуулалтын ажил хоцорч байгааг анхаарах хэрэгтэй.

Чөлөөт бүсийн хөгжилд хөрөнгө оруулагч чухал үүрэгтэй бөгөөд дэлхийн ихэнх улсууд чөлөөт бүсийг хувийн хэвшилтэй хамтран байгуулсан. Хөрөнгө оруулагч нийтлэг хүчин зүйлээс гадна чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийхдээ улс төрийн болон эдийн засгийн тогтвортой байдал, хувийн өмчид хандах соёл, олон улсын гэрээнд хандах уламжлал зэргийг харгалзан шийдвэрээ гаргадаг. Сүүлийн жилүүдэд улс төрийн болон эдийн засгийн тогтворгүй байдал хөрөнгө оруулагчдыг итгэлийг сулруулж хувийн өмчид халдах тохиолдол гарч байгаа нь чөлөөт бүсийг хөгжүүлэхэд бэрхшээл болж байна.

### **3. ДҮГНЭЛТ**

Чөлөөт бүс байгуулсан зорилго нь улсынхаа нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэд технологи оруулах замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх боловч бодит байдал дээр аль чөлөөт бүсэд бүртгэлтэй нь олон, үйл ажиллагаа явуулж байгаа нь цөөхөн байгаа нь аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулах орчин бүрдээгүй, хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө эрсдэлгүй өсгөх боломж хязгаарлагдмал байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Эрх зүйн зохицуулалтын хувьд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон урамшууллыг тодорхой хэмжээнд шийдэж өгсөн боловч тухайн бүсийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт орхигдсноос үр ашиггүй байх нөхцөл үүсч байгааг харгалзан үзэх шаардлага байна. Мөн “Хүнсний тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, экспортолж, импортолно” гэсэн заалтыг Гаалийн байгууллага баримтлан ажилласнаар “Чөлөөт бүсийн тухай” хуулийн 16.1.4. дахь заалт буюу зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх” гэсэн заалттай зөрчилдөж байгаа учир цаашид хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Монгол Улсын хөрш орнуудтай хийх эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжих тэлж хамтарсан томоохон төсөл, хөтөлбөрүүд батлагдсан боловч улс төрийн тогтворгүй байдал, гадаад бодлогын залгамж чанаргүй байдал зэрэг хүчин зүйл нь цаг хугацаа алдах, эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх үр дагавартай тул улс төрийн тогтвортой байдал чөлөөт бүсийн хөгжилд ч чухал асуудал гэдгийг анхаарах шаардлагатай.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Чөлөөт бүсийн тухай хууль (2015)
3. Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай конвенц (1973)
4. Монгол Улсын Их Хурлын тогтоол (1995) №87
5. Монгол Улсын Их Хурлын тогтоол (2002.) №38
6. Монгол Улсын Их Хурлын тогтоол (2005.12.01) №74

7. Отгонсайхан. Н (2009) “Олон улсын бизнес” Улаанбаатар хот: Монгол
8. Долгорсүрэн. Ц (2017) “Олон улсын худалдаа” Улаанбаатар хот: Монгол
9. <http://www.parliament.mn/n/mrхо> Цахим парламент
10. <http://www.altanbulag.gov.mn/500.html> Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн алба

## **МОНГОЛ УЛСЫН 100** жилийн хүн амын өсөлтийн төлөв байдал, хэтийн ХАНДЛАГА

**Доктор (Ph.D) Г.Жаргал**<sup>1,a</sup>, **Доктор (Ph.D) Н.Сэлэнгэ**<sup>2,b</sup>

Удирдлагын Академийн Менежментийн тэнхим

<sup>2</sup> Мандах их сургуулийн Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхим

<sup>a</sup> [Jargal15g@gmail.com](mailto:Jargal15g@gmail.com), <sup>b</sup> [selenge@gmail.com](mailto:selenge@gmail.com)

### **Хураангуй**

*Тус судалгаагаар Монгол Улсын хүн амын 1918-2015 оны хоорондох 10 удаагийн тооллогын улс, бүс, аймаг, сумын дүн мэдээнд хугацааны цувааны шинжилгээг Холт-Винтерийн аргаар хийж, 2020-2045 оны хэтийн хандлагыг тодорхойлов.*

*XX зуунд манай улсын хүн амын өссөн зүй тогтлыг Хүн амын шилжилтийн онолоор тайлбарлаж, улс, нийслэл, аймаг, сумын хүн амын хэтийн төлөвийг тооцоолов.*

**Түлхүүр үг:** хүн амын тооллого, хүн амын шилжилтийн онол, хугацааны цувааг шинжлэх Холт-Винтерийн арга, хэтийн хандлага



## ОРШИЛ

Үзэгдэл: Дэлхийн улс орнуудад ХХ зууны 40-өөд оноос эрчимжсэн хотжилтын үзэгдэл, ХХI зууны эхэнд улам бүр өрнөсөөр байна.

Манай монголчууд олон зуун жилийн турш, өргөн уудам нутагтаа мал аж ахуй эрхлэн, жигд тархан суурьшиж байгаад, ХХ зууны эхэн үеэс Төрөөс хэрэгжүүлсэн хоршоолох (1925-1950 он), нэгдэлжих (1940-1960 он), аж үйлдвэржих (1950-1970 он) зорилтот хөтөлбөрийн үр дүнд 1950-1990 онд хот суурин (18 аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, 300 гаруй сум, нэгдлийн төв, төмөр замын өртөө,..) олноор байгуулагдаж, шилжилт хөдөлгөөн өрнөж, хотжих үзэгдэл эрчимжсэн билээ. Хүн амын шилжилт хөдөлгөөн болон тухайн үед хэрэгжүүлсэн төрөлтийг дэмжсэн бодлого, эрүүл мэндийн салбарын хөгжлийн үр дүнд хүн амын тоо 4-5 дахин нэмэгдсэн байна.

Улс орнуудын хөгжлийн нийтлэг жишиг, олон талт даяаршилтай мөр зэрэгцэн манай улсад (1950-2010 он) хотжилт эрчимтэй өрнөж байгаа нь нийгмийн болон бизнесийн үйлчилгээ төрөлжин хорших, эдийн засгийн хувьд бүтээмж, орлого, ДНБ өсөн нэмэгдэх, хувь хүмүүс мэргэших, чадваржих зэрэг давуу талуудыг бий болгосоор байна.

Ерөнхий асуудал: Манай улсад өрнөж буй хотжилт болон хүн амын шилжилт хөдөлгөөн зөвхөн нэг төвтэй буюу Нийслэл-Улаанбаатарт төвлөрсөн онцлогтой байна. Аймгуудын төв болон томоохон 9 суманд 8500-аас дээш иргэд суурьшиж, хотжилт үүсэж байгаа боловч энэ нь УБ хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах хэмжээнд байж чадахгүй байна.

Хотжилт болон хөдөөгийн хүн амтай холбоотой тулгамдсан олон асуудлыг шийдэхэд Хүн амын хэтийн хандлагыг<sup>15</sup> тодорхойлох, түүнийг бүх төвшний төлөвлөлтөд хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Судалгааны зорилго: Манай улсын хүн амын 1918-2015 оны төлөв байдал, 2020-2045 оны хэтийн хандлагыг улс, аймаг, сумаар тооцоолж, судалгааны таамаглалыг шалгана.

Хамрах хүрээ: Монгол Улсын хүн амын 1918-2018 оны (100 жил) хоорондох 10 удаагийн тооллогын (улс, нийслэл, 21 аймаг, 331 сум) дүн мэдээнд шинжилгээ хийж, 2020-2045 оны хэтийн хандлагыг улс, нийслэл, аймгаар хийж, сумдын төлөөлөл болгож Завхан аймгийн 24 сумаар тооцоолов.

Хүн амын төлөв байдал, хэтийн хандлагыг тодорхойлохын ач холбогдол: Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүн амын тоо болон өсөлтийг 15-30 жилээр тооцоолох нь **инженерийн дэд бүтэц** (цахилгаан, дулаан, усан хангамж, цэвэрлэх байгууламж, авто зам, зорчигч тээвэр, хог тээвэрлэлт устгал), **нийгмийн дэд бүтэц** (эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал, цагдаа, халамж,..)-ийн эрэлт болон ачааллыг төлөвлөх, шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх, зориулалтын барилга, байгууламжийг төлөвлөх суурь мэдээлэл болдог. Түүнчлэн хот, суурины бүсийн **байгаль экологи** (зуслан, амралт, аяллын маршрут,..), **бизнесийн** (ажил эрхлэлт, худалдаа, үйлчилгээ, банк, санхүү, театр, үзвэр) эрэлт хэрэгцээ, нөөцийг төлөвлөхөд хэрэглэдэг.

Тус судалгааны ажил нь Хүн амын тооллого болоод түүнд хийсэн судалгааны үр дүнг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд хэрэглэх практик ач ач холбогдолтой болно.

<sup>15</sup>Хэтийн хандлага - forecasting (eng.), прогноз (рус.)

# 1. СУДЛАГДСАН БАЙДАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## 1.1 Судлагдсан байдал

Манай улсын хүн ам зүй, шилжилт хөдөлгөөний тухай эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагын<sup>16</sup> судалгаануудыг тоймлон үзвэл уг ажилдаа ихэвчлэн 5-10 жил, 10-20 жилийн тооллогын дүнг хэрэглэсэн байна.

Монгол Улсын хүн амын хэтийн тооцоог ҮСХ-оос 2013, 2017 онуудад тооцоолж, нийтэд мэдээлсэн бөгөөд эдгээр сэдэвчилсэн судалгааг 2010-2040 он, 2015-2045 оны байдлаар хийхдээ улс, бүсийн төвшний хэтийн тооцоог бүрэлдэхүүний (төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн) аргаар<sup>17</sup>, аймгийн төвшний хэтийн тооцоог харьцааны аргаар<sup>18</sup> тус тус хийсэн бөгөөд төрөлтийг (аажим, дундаж, хурдацтай буурах) гурван хувилбараар тооцоолсон байна. Ингэхдээ 2000 оноос хойшх (10-20 жил) мэдээлэлд тулгуурлаж нас, хүйсийн бүтцийн өөрчлөлт, төрөлтийн нийлбэр коэффициент, насны шилжилтийг тооцсон онцлогтой байна (ҮСХ, 2013), (ҮСХ, 2017).

Эдгээр ажил нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалтын программаар улс, аймгийн хэмжээнд нас, хүйсээр ангилж, 2010-2045 оны байдлаар хийсэн давуу талтай юм.

Орон нутгын хүн амын хэтийн тооцооны хэрэгцээ: Хүн амын төлөв байдал, хэтийн хандлагыг ЗЗНД<sup>19</sup>-ийн нэгж буюу аймаг, хот, аймгийн төв, хөдөөгийн сумаар ялгасан судалгаа одоогоор хийгдээгүй байна. Нийгэм-эдийн засгийн бүх салбарын (яам, агентлагуудын) иж бүрэн цогцолбор төлөвлөлт, орон нутгийн (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо) хөгжлийн асуудлыг шийдэхэд Хүн амын өсөлтийн хэтийн хандлагыг 15-30 жилээр тооцоолох хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа тул дараах судалгааг хийв.

## 1.2 Судалгааны асуудал, таамаглал, онол

Судалгааны асуудал 1. Манай улсын хүн ам 1950-1990 онд 2,5-2,9 хувь болж өсөж, 1990-2015 онд 1,4-2,1 хувь (дундаж 1,9%) болж буурсан нь Хүн амын шилжилтийн III үе шатанд орж<sup>20</sup>, улмаар хүн амын өсөлтийн хувь буурах хандлагатай болсон байна. Манай улс 1920-оод оноос хүн амаа өсгөх бодлого баримталж ирсэн боловч 1990 оноос буурах болсон нь хүн ам зүйд үүссэн томоохон асуудал юм.

*Тухайлбал*, Эрүүл мэндийн салбарт наслалтыг уртасгах, эх хүүхдийг эрүүл төрүүлэх, хүүхдийн эндэгдлийг бууруулах хөтөлбөрүүд хэрэгжиж, эерэг үр дүн гарч байгаа боловч осол гэмтлээр нас барахыг багасгах<sup>21</sup>, төрөлтийг нэмэгдүүлэх нь нийгэмд тулгамдсан бөгөөд хамтын оролцоо шаардсан асуудал болоод байна.

Судалгааны асуудал 2. Манай улсын 1990-2015 оны хүн амын өсөлтийн дундаж 1,9 хувь бөгөөд УБ хотод 2,5-6,7 хувь болж өссөн, харин аймаг, сумын хэмжээнд 0,7-0,9 хувь болж буурсаар байна. Энэ нь нэг төвт хотжилт<sup>22</sup> эрчимжих тутам сумын хүн ам буурч

<sup>16</sup> ҮСХ “Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага”, 2017 он

<sup>17</sup> Бүрэлдэхүүний арга - cohort component method;

<sup>18</sup> Үелрэл харьцаа болон дифференциал өсөлт арга -cohort relation and differential growth method;

<sup>19</sup> ЗЗНД - Засаг захиргаа, нутаг дэвсгэр

<sup>20</sup> А.Амарбал “Манай улс энэ зурвас үеийг л зөв ашиглавал хүн амаа өсгөж чадна”, ярилцлага, 2013.06.07; <http://mongolnews.mn>

<sup>21</sup> Засгийн Газар, ЭМЯ “Осол, гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөр” 2018 он, Монгол Улсын хүн амын дунд гадны шалтгааны улмаас нас барах, өвчлөх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 2017 оны байдлаар өвчлөлийн 5 дахь, нас баралтын 3 дахь шалтгаан болж байна.

<sup>22</sup> Хотжилт (urbanization, city planning) нь Хот сууринд амьдрах хүний тоо ихсэн, улс орны амьдралд хотын үүрэг нэмэгдсэн, хот суурин газрын амьдралын хэв маяг өргөн тархах үйл явц юм. Хотжилт өндөртэй оронд нийт хүн амын 50-аас дээш хувь нь хотод оршин сууж байна.



байгааг харуулж байна. Иймд хот, хөдөөгийн хүн амын өсөлтийг тэнцвэржүүлэх асуудал нь төрийн бодлогын хэмжээнд авч үзэх асуудал болсон байна.

Таамаглал 1: Манай улсын хувьд хотжилт, хүн амын өсөлт хоёр нь хамааралтай байна. *Өөрөөр хэлбэл*, 1950 оноос эхэлсэн хотжилтын явцад хүн амын өсөлт хурдацтай нэмэгдсэн байна.

Таамаглал 2: Манай улсын хүн амын өсөлтийн хувь 1950-1990 онд эрчимтэй өссөн боловч 1990-2010 онд буурах хандлагатай болсон. Энэ нь Хүн амын шилжилтийн III үе шатанд орсныг харуулж байна.

Таамаглал 3: Манай улсын хүн амын өсөлт 2020-2045 онд 3,3-4,6 сая; УБ хотын хүн ам 1,5-2,4 сая, аймгийн хүн ам 1,7-2,2 сая, хөдөөгийн сумын хүн ам 1-1,2 сая болох төлөв хандлагатай байна. *Тухайлбал*, Хөдөөгийн сумын хүн амын өсөлтийн хувь 0,7-0,9 болж буурах буюу зарим сум 100-500 хүн амтай болох хандлагатай байна.

Тухайн улс орны хүн ам зүйн өсөлт, бууралтыг *Хүн амын шилжилтийн онол*<sup>23</sup>-оор ерөнхий 3 үе шатаар тайлбарладаг. I үе шатанд төрөлт, нас баралтын хувь хоёулаа өндөр учраас өсөлтийн хувь өндөр байх потенциалтай байдаг. II үе шатанд төрөлт, нас баралтын хувь хоёулаа буурах учраас шилжилт эхэлнэ. Төрөлтийн хувь буурах боловч нас баралтын хувийн бууралт түрүүлж энэ хоёр харьцаа өөрчлөгдөж, улмаар өсөлтийн потенциал нэмэгддэг. III үе шатанд нас баралтын хувь маш доогуур байж, төрөлт буурснаар хүн амын өсөлтийн хувь буурах, зогсох хандлагатай болдог.

### 1.3 Хүн амын тооллогын өгөгдөл шинжлэх арга

Монгол Улсын хүн амын 1918, 1933, 1944, 1956, 1969, 1979, 1989, 1990, 2000, 2010 оны тооллого, 1995, 2005, 2015 оны завсрын тооллогын улс, аймаг, сумын дүн мэдээг эх олонлог болгов (ҮСХ, 2011), (ҮСХ, 2014), (ҮСХ, 2015). 1933, 1944, 1956 оны тооллогын дүнг<sup>24</sup> эдүгээх нэр бүхий сумдад харгалзуулж, 10 удаагийн тооллогын мэдээг төв, хөдөөгийн сумаар ялгаж шинжилгээ хийж, хотжилтыг тооцоолов.

Шинжилгээний арга: Манай улсын 100 жилийн хүн амын тоо, түүний өсөлтийг ажиглавал хугацааны цуваа нь тодорхой хэмнэлтэй, шугаман бус зүй тогтолтой байна. Иймд хугацааны цувааг шинжилдэг Холт-Винтер (Holt<sup>25</sup> and Winter<sup>26</sup>)-ийн аргыг хэрэглэж тооцоолол хийж, 2020-2045 оны хэтийн хандлагыг Улс, Бүс, Аймаг, Нийслэл, Сум гэсэн 4 төвшинд тодорхойлж, судалгааны таамаглалыг шалгав.

Холт-Винтер аргаар хугацааны цувааг (тренд) экспоненциал тэгшитгэлээр прогноз хийхдээ <sup>1</sup>Хугацааны цувааны өнгөрсөн, одоогийн төвшинг үнэлж, <sup>2</sup>Үнэлсэн утгуудад суурилж цувааны ирээдүйн утгуудыг тооцоолох<sup>27</sup> бөгөөд улирлын хэмнэлтэй<sup>28</sup> үед II загварын 4 томьёог хэрэглэдэг. Үүнд:

$$\bar{X}_t = * \left( \bar{X}_{t-1} + T_{t-1} \right) + (1 - *) * X_t / F_{t-s}, \quad 0 \ll 1 \quad (1)$$

<sup>23</sup> Demographic Transition Theory (Варрен Томпсон, 1929; Франк Нотестей 1945; Кинсли Дэвис 1945; Лижери 1962; Коале 1986;)

<sup>24</sup> ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчоо, 2018 оны 9 сар

<sup>25</sup> Charles C Holt (1921-2010 он) Чикагогийн их сургуулийн профессор, 1957 онд үйлдвэрлэл, бараа материал, ажиллах хүчний чиг хандлагыг урьдчилан тооцоолох арга боловсруулсан.

<sup>26</sup> Холстын шавь Peter R. Winters 1960 онд улирлын (давтамж) хэлбэлзлийг нэмж тооцоолох арга болгож өргөжүүлсэн.

<sup>27</sup> (Наранчимэг.Ч, Ганзориг.Д, 2011 хууд. 265).

<sup>28</sup> Улирлын нөлөөлөлгүй, улирлын нөлөөлөлтэй хугацааны цувааны гэж ангилдаг.

$$T_t = \alpha \bar{T}_{t-1} + (1 - \alpha) (\bar{X}_t - \bar{X}_{t-1}), \quad 0 << 1 \quad (2)$$

$$F_t = \beta F_{t-s} + (1 - \beta) X_t / \bar{X}_{t-1}, \quad 0 << 1 \quad (3)$$

$$\hat{X}_t = \left( \bar{X}_n + h * T \right) * F_{n+h-s}, \quad h = 1, 2, \dots, S \quad (4)$$

$X_t$  - t хугацаан дахь анхны цувааны утга

$\bar{X}_t$  - үнэлсэн утга

$T_t$  - трендийн үнэлсэн утга

$F_t$  - хэмнэлийн нөлөөлөл

$\alpha, \beta$  - тэгшитгэх коэффициентүүд

S - хэмнэлийн хэмжээг буюу 25 жилийн давтамжтай гэж үзэв.

Тооцоолол, бодолт: Манай улсын хүн амын 1918-1922 оны тооллогын дүн ЗЗНД-ийн нэгжийн хуучин нэрээр, 1933-2015 оны тооллогын дүн аймаг, сум бүрээр байгаа давуу талтай тул (1), (2), (3), (4) томъёогоор бодох боломжтой юм. Ингэхдээ, 1918-2015 оноор Улсын хэмжээнд, 1933-2015 оноор аймаг, нийслэл, сумаар тус тус тооцоолов. Хугацааны цувааны тэгшитгэх  $\alpha, \beta$  коэффициентүүдийг улс, аймаг, нийслэл, сумын хувьд тус бүрд тооцоолж, тодорхойлов.

Хүснэгт 1. Хугацааны цувааны тэгшитгэх коэффициент ( $\alpha, \beta$ )

Тэгшитгэх коэффициент	Улс, бүс, Нийслэл	Аймгуудын дундаж	Өмнөговь	Сумдын дундаж	Завхан Нөмрөг	Завхан Яруу
$\alpha$	0,112	0,014	0,014	0,014	0,006	0,014
$\beta$	0,085	0,015	0,011	0,015	0,001	0,015
$\gamma$	0,031	0,010	0,010	0,010	0,010	0,010

Тайлбар: Тэгшитгэх  $\alpha, \beta$  коэффициентийн хувьд Аймгуудын дунджаас ялгарах Өмнөговь, Сумдын дунджаас ялгарах Завхан аймгийн Нөмрөг, Яруу сумыг харьцуулан бичив.

1933-2015 оны дүн мэдээнд  $\bar{X}_t$  - үнэлсэн утга,  $T_t$  - трендийн үнэлсэн утга,  $F_t$  - хэмнэлийн нөлөөлөл тус бүрийг тооцоолж гарсан үр дүнд суурилж, 2020-2045 оны прогнозыг хийв. Прогнозыг хүн амын тоо, өсөлтийн хувиар тус тус тооцоолов.


## 2. ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

### 2.1 Монгол Улсын хүн амын өсөлт, хэтийн хандлага

**1.1.** Манай улсын хүн амын 1918-2015 оны тооллогын дүнгээс үзвэл 1918 онд 647,5 мянга байсан бол 2015 оны байдлаар 3 сая 41,0 мянга болсон буюу 100 жилийн (XX-XXI зууны эхэн) хугацаанд 4,7 дахин нэмэгдсэн байна.


1918-1956 онуудад жилд дунджаар 3936 хүн нэмэгдэж байсан бол 1963-1989 оны хооронд жилд дунджаар 34809 хүн нэмэгдэж 5-9 дахин өсөж ирсэн байна.

2020-2045 онд хүн амын тоо 3,3-4,6 сая (3342,3-4630,2 мянга) болж, жилд дунджаар 35-60 мянгаар нэмэгдэх хандлагатай байна.



**Зураг 1. Монгол Улсын хүн амын тоо: 1918-2018 он, Прогноз 2020-2045 он**

1.2. 1918-2015 онуудад хүн амын өсөлт 0,3-3,3 хувийн хооронд 13 дахин хэлбэлзэлтэй байсан бөгөөд 1969-1995 онд хамгийн эрчимтэй 2,9-3,3 хувийн өсөлттэй жилүүд байгаад 2000 оноос хойш 1,8-2,1 хувийн хооронд хэлбэлзэж байна. 2020-2045 онд 1,3-2,1 хувийн хооронд хэлбэлзэл, ерөнхийдөө 1,3 хувь болон буурах хандлагатай байна.




**Зураг 2. Монгол Улсын хүн амын өсөлт: 1918-2018 он, Прогноз 2020-2045 он**

## 2.2 Аймаг, Нийслэлийн хүн амын өсөлт, хэтийн хандлага


2.1. Нийслэлийн хүн амын тоог Аймгуудын хүн амын тоотой харьцуулан үзвэл 1933 онд Нийслэлд 24,928 хүн байсан бол 2015 оны байдлаар 1,396,288 хүн болж, 56 дахин нэмэгдсэн. Аймгуудад (тухайн үед 13 аймаг) 1933 онд 713,272 хүн байсан бол 2015 оны байдлаар 21 аймагт 1,644,742 болж 2,3 дахин нэмэгдсэн байна. Энэ нь манай улсын хувьд ХХ зуунд Нийслэл Улаанбаатар хот буюу нэг төвтэй хүн амын төвлөрөл хүчтэй явагдсаныг

харуулж байна. 2020-2045 онд Нийслэлд 1,5-2,4 сая, аймгуудад 1,7-2,2 сая хүн ам суурьших хандлагатай байна.



**Зураг 3. Нийслэл болон 21 Прогноз 2020-2045 аймгийн хүн ам: 1933-2015 он, он**


**2.2.** Аймаг, Нийслэлийн хүн амын өсөлтийг харьцуулж үзвэл 1933 онд Нийслэлд хүн амын 3 хувь байсан бол 2015 онд 46 хувь болж өссөн. Энэ өсөлт үргэлжилж 2020-2045 онд 48-52 хувь болж өсөх хандлагатай байна. 1933 онд Аймаг, суманд (13 аймаг, 520 орчим сум) хүн амын 97 хувь байсан бол 2015 онд (21 аймгийн 331 сум) 54 хувь болж буурч, цаашид энэ бууралт нь 52-48 хувь болж үргэлжлэх хандлагатай байна.



**Зураг 4. Нийслэл болон 21 аймгийн хүн амын харьцаа: 1933-2045 он**

Аймаг, Нийслэлийн хүн амын харьцаа 45-55 орчим хувьтай болж тогтворжих хандлагатай боловч 21 аймаг, тэдгээрийн 331 сум, төдий тооны суурин, харин нэг Нийслэл, түүний 9 дүүрэг байгаа гэдэгт анхаарал хандуулбал эрс ялгаа харагдаж байна.

**2.3.** Нийслэлийн хүн амын өсөлтийг үзвэл Нийслэлийн хүн амын өсөлт 1944-1989 онд 5-17,9 хувь болж, оргил нь 1956 он байсан байна. 1950-1970 онд дэлхийн II дайн дараах аж үйлдвэржих хөдөлгөөн, УБ хотын барилгажилт, Замын үүд-УБ-Алтанбулаг чиглэлийн төмөр зам зэрэг бүтээн байгуулалт ихээхэн эрчимтэй байсантай шууд холбоотой юм. Эдгээр онуудын Хүн амын өсөлтийн хурд 1989-1995 онд 3,6-2,9 хувь болж саарсан боловч 2000-2005 онд 3,7-6,7 болж эргэж өсөж, 2015 оны байдлаар 2,1 хувьтай байна. Сүүлийн 5 жилд Нийслэл чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хүн амын өсөлт бага зэрэг саарах хандлагатай боловч нэгэнт 1,4-1,5 сая болсон хүн амын өсөлт потенциал аа хадгалж, өсөлт нь тогтворжих боловч тооны хувьд нэмэгдэх хандлагатай байна.




**Зураг 5. Аймаг, Нийслэлийн хүн амын өсөлт, хандлага: 1933-2045 он**

**2.4.** Аймагуудын хүн амын өсөлт 1933-2015 онд ерөнхийдөө тогтмол байгаа бөгөөд хамгийн их өсөлт 1969-1979 онд 2,8-2,9 хувь, хамгийн бага нь 2005-2010 онд (-0,4)-(-0,8) хувь болж буурсан байна. Хотжилтод татагдах шилжилт хөдөлгөөнөөр 2020-2045 онд 1,3-0,9 хувь болж тогтмол буурах хандлагатай байна.

**2.3 Аймаг, сумын хүн амын өсөлт, хэтийн хандлага**


**3.1.** Шинжилгээний үр дүнг нарийвчлах зорилгоор Аймагуудын төв болон сумдын (331) төвийн сум, хөдөөгийн сум тус бүрээр авч үзэв. **Төвийн сум**-анд аймагуудын төвийн 21 сум (орон нутгийн хот) болон 2015 оны байдлаар 8500-аас дээш хүнтэй 9 сум (БӨ Цэнгэл; За Тосонцэнгэл; ДГ Замын-Үүд; Өв Хархорин; Өв Уянга; Сэ Мандал; Сэ Сайхан; Хо Булган; Хэ Дархан, Бор-Өндөр)-ыг хамруулж, бусад 301 сумыг **хөдөөгийн сум** гэж үзэж, тооцоолол хийв.



Зураг 6. Төв болон Хөдөөгийн сумын хүн амын тоо, хандлага: 1933-2045 он

Төвийн сумдын нийт хүн амын тоо 2015 онд 737,2 мянга, хөдөөгийн сумдынх 907,6 мянга байна. Үүнийг төвийн сум 30, хөдөөгийн 301 сумаар дундаж ( $737,2/30=24,6$  мянга;  $907,6/301=3,0$  мянга) тооцож үзвэл 8 дахин зөрүүтэй байна. 2020-2045 онд төвийн сумдын хүн амын тоо 808-1024 мянга, хөдөөгийн сумдын хүн амын тоо 966 мянгаас 1,2 сая болох хандлагатай байна.

**3.2.** Төвийн сумын хүн амын өсөлтийг үзвэл 1933-1963 онд 0,9-20,1 хувь болж эрс нэмэгдэж, 1963-1989 онд 9,5-3,5 хувь болон буурч, 1995-2000 онд бууралт үргэлжилж (-0,7)-(-0,6) хувь болж, харин 2005 оноос 1,4-1,8 хувь болж өссөн байна. 2020-2045 онд дунджаар 1,3 хувь өсөх хандлагатай байна.



Зураг 7. Төв болон Хөдөөгийн сумын хүн амын өсөлт, хандлага: 1933-2045 он

Хөдөөгийн сумын хүн амын өсөлтийг үзвэл хамгийн их нь 1979 онд 2,9 хувийн өсөлттэй, 1995 оноос хойш дунджаар 0,6-0,9 хувийн бууралттай байна. Цаашид үргэлжилж 2020-2045 онд дунджаар 0,8 хувь буурах хандлагатай байна. Энэ нь 1950 оноос шилжилт хөдөлгөөн Сумаас аймаг (15%), Аймагас УБ хот (35%), Сумаас УБ хот (60%) гэсэн чиглэлтэй явагдаж, харин **Хөдөөгийн сум** руу чиглэсэн хөдөлгөөн явагдахгүй байгаатай холбоотой юм.


**3.3.** 2020-2045 онд 16 аймгийн хүн ам дунджаар 1-1,2 хувь өсөх, бусад 5 аймгийн (Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Төв, Дархан-Уул) хүн ам 0,6-0,9 хувийн буурах хандлагатай байна. Хүн ам буурах үзэгдэл нэгэнт үүсэж, цаашид үргэлжлэх хандлагатай болсон аймгуудаас Завхан аймгийг жишээлэн үзье. Тус аймгийн 24 сумын зөвхөн 1 сум буюу Тосонцэнгэл сумын хүн ам өсөх (2015 онд 8,885; 2020 онд 9,829; 2025 онд 10,428; 2030 онд 11,050; 2035 онд 11,118; 2040 онд 11,986; 2040 онд 12,476), бусад 23 сумын (*тухайлбал*, Завханмандал, Нөмрөг, Сантмаргац, Сонгино, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Яруу, Асгат,) хүн ам 100-500 болж буурах эрсдэлтэй байна.

### 3. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ТАЙЛБАР

#### 3.1 Таамаглал шалгасан үр дүн

“Манай улсын хувьд хотжилт, хүн амын өсөлт хоёр нь хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, 1950 оноос эхэлсэн хотжилтын явцад хүн амын өсөлт хурдацтай нэмэгдсэн байна” гэсэн 1-р таамаглал нь шинжилгээний үр дүнгээр батлагдав.

Манай оронд өрнөсөн Хотжилт нь 1933-1989 онд 6,1-51,3 хувьд хүрч өсөөд, 1990-1995 онд 49,4 хувь болж бага зэрэг буурч, 2000-2015 оны байдлаар 51,5-64,8 хувь болж эргэж өссөн байна. 2020-2045 онд 65,7-69,3 хувь болох хандлагатай байна. Хотжилт нэмэгдэх тутам хөдөөгийн сумын хүн ам эрс буурсаар байна.



**Зураг 8. Хотжилт ба хөдөөгийн хүн амын харьцаа**

1950 оноос эхэлсэн хотжилтын явцад УБ хотын хүн амын тоо 3-27 хувь болж өссөн бол зах зээлийн нийгэмд шилжсэнээр 1995-2015 онд 28-46 хувь болж өссөн байна. 1970-1990 онд шилжилт хөдөлгөөнийг захиргааны аргаар зохицуулж ирсэн бөгөөд зах зээлийн харилцаанд энэ нь тохирохгүй болсон билээ. Нэг төвт хотжилтоос олон төвт хотжилтын бодлогыг хэрэгжүүлэхгүй бол 2020-2045 онд УБ хотод хүн амын 48-52 хувь суурьших, хүний тоо 1,5-2,4 сая болох хандлагатай байна. Энэ нь Хотжилт болоод иргэдийн шилжилт хөдөлгөөн, суурьших бодлогыг Улсын хэмжээнд авч үзэж, бодиттой ажил хэрэгжүүлэх шаардлага тулгарсныг харуулж байна.

“Манай улсын хүн амын өсөлтийн хувь 1950-1990 онд эрчимтэй өссөн боловч 1990-2010 онд буурах хандлагатай болсон. Энэ нь Хүн амын шилжилтийн III үе шатанд орсныг харуулж байна” гэсэн 2-р таамаглалыг ҮСХ-ны хүн ам зүйчид урд өмнө дурдаж байсныг энэ удаад Холт-Винтерийн аргаар батлав.

Манай улсын 1918-2015 оны хүн амын тооллогын дүн мэдээ, өсөлтийг шинжилж үзвэл 1918-1924 онд зогсонги<sup>29</sup>, 1925-1963 онд огцом өсөх (0,09-2,9%), 1963-1989 онд жигд өсөх (2,9-3,3-2,8%), 1990-2000 онд огцом буурах (2,8-0,9), 2005-2015 онд бага зэргийн өсөлт, бууралт ээлжилсэн, ерөнхийдөө буурах (1,2-2,1-1,4) зүй тогтол ажиглагдаж байна (Зураг 2). Манай орны Хүн ам зүйн шилжилтийн II үе шат харьцангуй цөөн (1970-1990 он) жил үргэлжилж, 1990-ээд оноос III үе шатанд огцом шилжсэн нь шинжилгээнээс харагдаж байна.

Манай улсын хүн амын өсөлт 2020-2045 онд 2,1-1,4 хувь болж жигд буурах; Хот, суурины хүн амын өсөлт 3,5-1,6 хувь болж тогтворжих хандлагатай байна.

“Манай улсын хүн амын өсөлт 2020-2045 онд 3,3-4,6 сая; УБ хотын хүн ам 1,5-2,4 сая, аймгуудын нийт хүн ам 1,7-2,2 сая, хөдөөгийн сумдын нийт хүн ам 1-1,2 сая болно. Хөдөөгийн сумын хүн ам 0,7-0,9 хувь болж буурах буюу зарим сум 100-500 хүн амтай болох хандлагатай байна” гэсэн 3-р таамаглал нь шинжилгээгээр батлагдав. Хүн амын тоо 2000-аас бага бөгөөд гаднаас нэмэгдэх шилжилт хөдөлгөөнгүй суманд “Зан заншлын хувьд ижил төстэй нутгийн хүн амын өсөлт зогсох” гэдэг нийгэм, соёлын хүчин зүйл тодорхой хэмжээгээр үйлчилж байгааг харуулж байна.

Аймаг, сум хийгээд алслагдсан сумын хувьд тодорхой бодлого хэрэгжүүлэхгүй бол 260 орчим (нийт сумын 78,5%) сумын хүн ам эрс цөөрөх, ялангуяа Говь-Алтай, Завхан, Өмнөговь аймгийн сумдын хүн амын тоо 100-500 болох төлөвтэй байна. Сумдын хүн амын дундаж 2015 оны байдлаар 3000 байгаа бөгөөд 1700-гаас доош 38, 1000-аас доош хүн амтай 19 сум<sup>30</sup> байна. Сумын хүний тоо 1000-аас доош байх нь нийгэм, эдийн засгийн хувьд өгөөжгүй төдийгүй хүн амын цус ойртолт болж үндэсний аюулгүй байдалд нөлөөлдөг болохыг эрдэмтэд<sup>31</sup> онцолсоор байна.

### 3.2 Шинжилгээний арга зүйн хувьд тодотгох нь:

Итгэх төвшин: 1918-2015 оны Хүн амын тооллогын дүн, Холт-Винтерийн аргаар хэтийн хандлага тооцоолсон дүн хоёрыг харьцуулахад 98,5%-99,8% буюу дундаж 99,1 хувь байгаа нь энэхүү аргын итгэх төвшин (найдвартай байдал)-г харуулж байна. Мөн ҮСХ-ны 2013, 2017 онд хийсэн 2020-2045 оны хэтийн хандлагатай тус шинжилгээний үр дүнг харьцуулсан болно.

Хүн амын өсөлтийн хэмнэлийн зүй тогтол: Монгол Улсын 1918-2015 оны хүн амын тоо, өсөлтийг шинжилсэн үр дүнгээс үзвэл хугацаанаас хамаарсан **25 жилийн давтамж бүхий хэмнэлийн зүй тогтол** ажиглагдаж байна. Энэ нь ҮСХ-оос нөхөн үржихүйн дундаж<sup>32</sup> насыг 25-29 гэж байгаатай<sup>33</sup> ойролцоо байна.

<sup>29</sup> 1924 он хүртлэх хүн амын бүртгэл хүн, мал, эд хөрөнгийн хамт хийгдэж байжээ.

<sup>30</sup> Жаргал, Г. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь: Аймаг, сум, баг, Нийслэл, дүүргийн лавлах 1911-2017 он. УБ, 2018. 38 тал

<sup>31</sup> Батсуурь, Ж, Лхагвасүрэн, Ц, Энхмаа, Э, “Монголын хүн амын цус ойртолт бол үндэсний аюулгүй байдалд холбогдох нэн чухал асуудал”, Статерги судлал 45 (1/2009), УБ, 28-47 тал

<sup>32</sup> Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2013-2015 он, Зураг 3.1.4., (ҮСХ, 2017 р. 28)

<sup>33</sup> Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент 25-29 насанд хамгийн их буюу 1000 эмэгтэйд 180 байна. (ҮСХ, 2016 хууд. 38)



Өмнө хийсэн кейс судалгаатай<sup>34</sup> харьцуулбал нөхөн үржихүйн дундаж нас XIX зуунд 20, XX зуунд 25 байсан бол XXI зуунд 30 болох хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, Нөхөн үржихүйн дундаж нас 100 жилд таван насаар нэмэгдэж байгаа нь хүн амын насны бүтцэд өөрчлөлт орох суурь болж байна. Үүний нэг илрэл нь хүн амын тоонд залуучуудын эзлэх хувь буурах, хөгшрөлт нэмэгдэх хандлага юм.

Судалгааны хязгаарлалт: Хүн амын хэтийн хандлагыг тооцоолохдоо улсын хэмжээнд гадаад шилжилт хөдөлгөөн, орон нутгийн хэмжээнд дотоод шилжилт хөдөлгөөн, мөн төрөлт, нас баралтыг авч үздэг бөгөөд тус судалгааны хувьд Илтгэлийн хэмжээ заасан тул энэ удаад ийнхүү хязгаарлав.

Санал: Манай улсын хүн амын тоо, өсөлтийг 100 жилээр үзвэл шугаман бус зүй тогтолтой байна. Хүн амын хэтийн хандлагыг бүрэлдэхүүний (шугаман тэгшитгэл, харьцаа) аргаар тооцоолж байгааг Хугацааны хэмнэлтэй цувааны (шугаман бус, экспоненциал тэгшитгэл) аргаар хослуулан тооцоолбол нарийвчлал өндөртэй үр дүн гарна гэж үзэж байна.

Хүн амын хэтийн тооцоог Аймаг, сум, баг, нийслэл, дүүргээр бодит байдалд илүү дөхсөн, нарийвчлал өндөртэй хийснээр түүнийг орон нутгийн (бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг) хөгжлийн төлөвлөлтөд хэрэглэх боломж нэмэгдэнэ гэж үзэж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. ҮСХ. Монгол Улс 100 жилд. УБ, 2011.
2. ҮСХ. Хүн амын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо. УБ, 2013.
3. ҮСХ. Монгол Улсын хүн амын тооллогын түүхэн товчоо. УБ, 2014.
4. ҮСХ. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2014. УБ, 2015.
5. ҮСХ. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2015 он. УБ, 2016.
6. ҮСХ. Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн тооцоо. УБ, 2017.
7. ҮСХ. Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага. УБ, 2017.
8. Статистикийн Төв газар. БНМАУ-ын Улс ардын аж ахуй 60 жилд. УБ, 1981.
9. МНР Центральная Статистическое. Итоги переписи населения и жилого фонда 1969 года МНР. УБ, 1972.
10. Батсуурь.Ж, Лхагвасүрэн.Ц, Энхмаа.Э, Монголын хүн амын цус ойртолт бол үндэсний аюулгүй байдалд холбогдох нэн чухал асуудал мөн, Стратеги судлал №45, УБ., 2009
11. Жаргал,Г. Сумын судалгаа: Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурь үнэлгээ. УБ, УА, 2004.
12. Жаргал, Г. Монгол орны хөгжлийн гарц: Сумын индекс буюу сумын хөгжлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд. УБ, ШУА, УА, ЭШБХ, 2009.

<sup>34</sup> Г.Жаргал “Удам ургийн холбоо”, I дэвтэр, УБ 2017 он; III дэвтэр, УБ 2018 он;

13. Жаргал Г. Монгол сум: Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хувьсал. УБ, УА, 2013.
14. Жаргал,Г. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь: Аймаг, сум, баг, Нийслэл, дүүргийн лавлах 1911-2017 он. УБ, 2018.
15. Жаргал,Г. Сэлэнгэ.Н, Судалгааны арга зүйд өөрөө сурах бичиг, УБ, 2018
16. Жон Р.Вик, Population. An introduction to concepts and issues; Увш.П., орч.ред., “Хүн ам онол, үзэл баримтлал, бүтэц шинж байдал”. УБ, 2005.
17. Майский.И.М. Орчин үеийн Монгол (XX зууны гараа). 1921.
18. Эрдэнэсүрэн.Б, Ц.Бадрах.Ц. Монгол Улсын хүн ам зүйн түүхэн товчоо. УБ, 2013.
19. Dudley Kirk, “Demographic Transition Theory, Population Studies”, 50 (1996), p 361-387, Great Britain
20. Stanley K Smith, David A. Swanson, Jeff Tayman, “The Springer Series on Demographic Methods and Population Analysis”, USA,2013, III Cohort Component methods;
21. <https://www.measureevaluation.org/resources/training/online-courses-and-resources/non-certificate-courses-and-mini-tutorials/population-analysis-for-planners/lesson-8/lesson-8-the-cohort-component-population-projection-method>
22. [https://www.researchgate.net/publication/299667904\\_Overview\\_of\\_the\\_Cohort-Component\\_Method](https://www.researchgate.net/publication/299667904_Overview_of_the_Cohort-Component_Method)
23. Holt-Winters Forecasting methods:  
<https://grisha.org/blog/2016/01/29/triple-exponential-smoothing-forecasting/> ;  
[https://en.wikipedia.org/wiki/Exponential\\_smoothing](https://en.wikipedia.org/wiki/Exponential_smoothing)

**МЕТАФОР ХЭРЭГЛЭЭГ ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТАНД ҮНДЭСНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ХЭВ  
ШИНЖЭЭР ИЛЭРХИЙЛЭХ ТУРШИЛТ СУДАЛГАА**

**С.Ганцэцэг<sup>1,a\*</sup> (Доктор, (Ph.D) Дэд Профессор)**

**Т.Сумъяа<sup>2,b</sup> (Докторант, Дэд Профессор)**

**Э.Оюун-Эрдэнэ<sup>3,c</sup> (Докторант, Ахлах багш)**

<sup>1,2,3</sup> Гадаад хэлний Тэнхим, Мандах Их Сургууль, Монгол улс

<sup>a</sup>[gantsetseg@mandakh.mn](mailto:gantsetseg@mandakh.mn), <sup>b</sup>[sumiya@mandakh.mn](mailto:sumiya@mandakh.mn), <sup>c</sup>[oyunerdene@mandakh.mn](mailto:oyunerdene@mandakh.mn)

**Хураангуй**

*Метафорыг илэрхийлэгч үгс дангаараа объектив утгатай үгсийн сангийн нэгж юм. Харин нийлэмжийн түвшинд утгын сэтгэлгээний субъектив чанарыг салбар шинжлэх*

*ухаануудын уулзварт судлах асуудлыг эрдэмтэд сонирхсоор байна. Метафорын энэхүү концептлаг шинж нь гадаад хэлийг сурч байгаа хүний сэтгэлгээний хэв шинжийг тэрхүү хэлээр илрэх соёлын менталитэд<sup>35</sup> уусгаж таниулах хэрэгцээ зайлиггүй урган гарч байна. Тиймээс бид судалгааны ажилдаа Мэргэжлийн англи хэлэнд илэрч буй метафор шинжийг үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс судалж, англи хэлний заах арга зүйг боловсронгуй болгох санал дэвшүүлж байна. Англи хэл судалж буй оюутнууд зорилтот болон үндэсний хэл, соёлын шүтэлцээт байдлыг төрөл бус хэлэнд зэрэгцүүлэн судалж, соёлын мэдлэг, чадамжтай мэргэжилтэн төлөвшихөд судалгааны ажлын ач холбогдол оршино.*

**Түлхүүр үгс:** мэргэжлийн англи хэл, заах арга зүй, метафор, сэтгэлгээний субъектив чанар, үндэсний сэтгэлгээний хэв шинж

## **ОРШИЛ**

Өнөөгийн хүн төвтэй нийгэмд конструктивизм, когнитивизм<sup>36</sup>, прагматизм, экзистенциализмын онолуудыг их, дээд сургуулийн сурганы арга зүйд баримталж, хөгжүүлэх сургалт, оюуны хөгжлийн суурь чиг хандлага болж байна. Эдгээр үзэл баримтлалууд нь суралцагчдын сонирхол, сэдлийг хөгжүүлэх, тэдний бодит хэрэгцээнд тулгуурласан шинжлэх ухаан хоорондын уялдаат зарчим бүхий сургалтын орчныг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийн уян хатан боловсруулалт, арга технологийн оновчтой хэрэглээг хангахад ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс үндэстнүүдийн соёлын ялгаа, орон зай, цаг хугацаа, эдийн засаг, нийгмийн амьдралын хэв маяг, үндэсний сэтгэлгээний онцлогийг метафороор

---

<sup>35</sup> Менталит-үндэсний сэтгэлгээний төлөвшил

<sup>36</sup> Когнитивизм-танин мэдэхүйн онол

илэрхийлэх хандлагыг төрөл бус хэлний зэрэгцүүлсэн судалгаанд авч үзэх шаардлага тулгарч байна.

## Судалгааны арга

Бид Мандах ИС-ийн оюутнуудад мэргэжлийн англи хэл-2 хичээлээр англи хэлний метафор хэрэглээг үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс зэрэгцүүлэн заах арга зүйн талаар тандалт болон туршилт судалгаа хийсэн үр дүнг доор танилцуулж байна.

### 1. ҮНДСЭН ХЭСЭГ

Метафорийн тухай ойлголтыг хамгийн анх Грекийн философич Аристотель “Туурвилзүй” бүтээлдээ чухалчлан авч үзсэн бөгөөд метафор нь эртнээс өрнө дорнын утга уянгын зохиол бүтээлд түгээмэл хэрэглэгдсээр иржээ. Түүнчлэн 1980-аад оноос хэл шинжээч Ж.Лакоф, М.Жонсон нар метафорын тухай онол үзэл баримтлалыг хэл шинжлэлийн судалгаанд дэвшүүлсэн. Тэд ерөнхий хэл шинжлэлийн үүднээс метафорын мөн чанар нь нэг юмны гол шинжийг өөр зүйлд оноож, ойлгож, хүлээж авахад оршдог бөгөөд энэ нь зөвхөн хэлэнд буюу өөрөөр хэлбэл үгэнд хамаарах төдий зүйл биш юм гэж тодорхойлж байжээ. (2002)

20-р зууны сүүлээс метафор судлалыг сэтгэц, танин мэдэхүй, бүтэц хэл шинжлэл гэх мэт салбар шинжлэх ухаануудын өргөн хүрээнд судлах болжээ. Сэтгэц хэл шинжлэлийн үүднээс хүний сэтгэхүйн үйл явц нэлэнхүйдээ метафорчлагдсан байдаг (Lakoff) гэж үзсэнээр бүтээлч сэтгэлгээ бол мэдээлэл авахаас эхлээд шийдэлд хүрэх хүртэл үргэлжлэх сэтгэхүйн нийлмэл үйл юм гэж тодорхойлдог (Ц.Оюунчимэг, 2012). Өөрөөр хэлбэл үйл явдлыг ахуй, юмс, үзэгдэл гэх мэт бодит ойлголтод тулгуурлан зүйрлэх, ёгтлох, тойруулах зэрэг хийсвэр аргаар бодьжуулж, илэрхийлэх явдал нь сэтгэхүйн үйлдлүүдтэй холбоотой байдаг гэж үздэг.

Метафорыг когнитив хэл шинжлэлийн концептуаль метафорын хүрээнд судлах болсон ба энэхүү онолыг анх Ж. Лакофф, М. Жонсон нар 1980 онд “*Metaphore dans la vie quotidienne*” номондоо тусгаж, метафорын тогтолцоо нь когнитив механизм мөн гээд хүний сэтгэхүйн явц их олон тохиолдолд метафорлог гэж үзсэн. Үүнээс үзэхэд ухахуун концепт<sup>37</sup> нь ухагдахуунаас үндэсний онцлогийг агуулснаараа ялгагддаг байна. Өөрөөр хэлбэл ухагдахуун нь уг юмны гол шинжийг заадаг бол ухахуун нь гол бус шинж (сэтгэл хөдлөл, дүрслэл, үнэлэмж)-ийг агуулсан байдаг гэж Ю.С.Степанов, В.А.Маслова (2007) нарын эрдэмтэд үздэг. Харин эрдэмтэн Ц.Магсар (2016) когнитив онолын үүднээс метафорыг тодорхойлохдоо бодит байдлыг танин мэдэх хэрэгсэл, хүний туршлагыг эрэмбэлж, ертөнцийн талаарх мэдлэг төсөөллийг бүтэцчилэх багаж хэмээн онцгойлон үзсэн. Энэ нь метафорыг бүтээгч үгс дангаараа бие даасан обьектив утгатай, үгсийн сангийн нэгж хэдий ч нийлэмжийн түвшиндээ сэтгэлгээний субъектив чанарыг агуулж байдгийн хувьд суралцагчийн танин мэдэх үйл ажиллагааг бүтээлч шийдлээр зохион байгуулах, сэдэлжүүлэх, тэдний бие даасан бүтээлч үйлийг хөгжүүлэхэд чиглэсэн орчин үеийн чиг хандлагатай нийцэж байгаа юм.

<sup>37</sup> Концепт-ухахуун (үндэсний онцлогийг агуулсан шинж )

Бүтэц хэл шинжлэлийн үүднээс Америкийн угсаатан зүй судлаач Бенжамин Ли Уорф, хэл шинжээч Эдвард Сапир нарын Сапир-Уорфын хэлний харьцангуй таамаглалаар хэлний бүтэц нь тухайн хэлээр яригч ард түмний сэтгэлгээ болон бодит ертөнцийг танин мэдэх арга хэлбэрийг тодорхойлно гэж үздэг байна (Carroll, 1958). Өөрөөр хэлбэл, өөр өөр хэлээр яригч бүлэг хүмүүс, ард түмэн ертөнцийг өөрөөр хүлээн авч, өөрөөр сэтгэдэг гэж үздэг. Тухайлбал, бүх ард түмэнд нийтлэг байдаг цаг, орон зайн категори нь өөр өөрөөр илэрч байдаг.

Энэхүү дэлхийн олон үндэстний сэтгэлгээний нийтлэг болон ялгаатай хэв шинжээс үүдэн гадаад хэлийг заах арга зүйн асуудалд нэг талаас соёлыг илэрхийлэх хэл, нөгөө талаас хэлээр илрэх соёл зэрэг ухагдахууны харилцан шүтэлцээний асуудалд олон судлаачид анхаарлаа хандуулж байна. Судлаач Чантал, Крозет нарын “Соёл хоорондын харилцааны чадамж-Хэлний боловсрол” бүтээлд гадаад хэлийг эзэмшиж байгаа хүмүүс зорилтот хэлээр (англи хэл) илэрч буй аспектүүдийг ойлгож, тэдгээрийг олон соёлын харилцаанд ашиглахад зорилтот хэл ба соёлын шүтэлцээт байдлыг ойлгосноор соёлын мэдлэг бүтээж, соёлын үнэлэмж төлөвшиж, улмаар соёл хоорондын харилцааны чадамж эзэмшдэг хэмээн судлаачид томъёолжээ (1995). Эрдэмтэн Ж.Баянсан (2002) соёл-хэлт үндэстний эртнээс нааш аж төрж ирсэн нутаг орон, түүний байгалийн байдал, эрхэлж буй аж ахуй, аж төрөх ёс буюу амьдралын хэв маяг, ёс заншил, шашин шүтлэг тэргүүтний өвөрмөц онцлогоос үүдэж тухайн юмс үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдал зэргийг үнэлэх үнэлэмжийн жишиг хэмжүүр эталонийг<sup>38</sup> бий болгосон байдаг гэж үзжээ. Жишиг хэмжүүр нь харьцууллаас үүсч, харьцуулалт нь хэл шинжлэл, уран зохиол судлалын үндэс цөм нь зүйрлэл үүсэх гол арга учир тойруулал, егөөдөл, ёгтлол, хэтрүүлэл нь эдгээрээс сурвалжтай нь тухайн үндэстний сэтгэлгээний хэв шинжийг тодорхойлох гэрч баримт болдог гэж эрдэмтэд үздэг байна. Энэ талаас нь авч үзвэл дэлхийн улс үндэстэн далд утгатай шууд бус нэрлэлт үүсгэх тухайлбал зүйрлэх, тойруулах, егөөдөх, зэрэг олон аргаар метафорыг хэрэглэдэг бөгөөд үүнийг хэрхэн ойлгох нь харилцагчийн суурь мэдлэгтэй холбоотой байдаг.

Бид МБИС-ийн оюутнуудад мэргэжлийн англи хэл-2 хичээлээр англи хэлний метафор хэрэглээг үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс зэрэгцүүлэн заах арга зүйн талаар тандалт болон туршилт судалгаа хийсэн үр дүнг доор толилуульж байна.

## 2. ТАНДАЛТ СУДАЛГАА

Мандах их сургуулийн мэргэжлийн англи хэл-2 хичээлийг судалж байгаа оюутнуудаас тандалтын болон туршилт судалгаа авч, анализ хийж дүгнэлээ. Тандалт судалгааны үр дүнг график 1,2-оор харуулав.


1-р даалгаварт “**eat-away at profit**” метафор (зүйрлэл)-ыг хэлц үйл үг, өвөрмөц хэлц, үйл үгийн алинд нь хамааралтайг сонгох асуулт оруулсан нь оюутнуудын англи хэлний үгзүйн болон хэлзүйн мэдлэгийг тандах зорилготой байлаа.

Энэ даалгаварт “Хэлц үйл үг” гэсэн хариултыг нийт судалгаанд оролцогчдын 40%, “Үйл үг” гэсэн сонголтыг 14% тус тус сонгосон нь суралцагчид үйл үг, хэлц үйл үгийг өвөрмөц хэлцээс нарийвчлан ялгаж мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

---


<sup>38</sup> Эталон-үндэсний соёлын үнэлэмжийн жишиг хэмжүүр

2-р даалгавраар мэргэжлийн англи хэлний агуулгын хүрээнд судлагдаж буй англи метафорыг (зүйрлэлийг) монгол хэлэнд зүйрлэх утгатай нь тохируулах асуулга нь төрөл бус хэлийг зэрэгцүүлэн судлаж байгаагийн хувьд эх хэл болон үндэсний сэтгэлгээний




онцлог хэрхэн илэрч байгааг тандахыг зорьсон.

Даалгаврын гүйцэтгэлийн дүнгээс нийт 5 оноо буюу бүх хэллэгийг зөв тохируулж чадсан суралцагч 32%, 4 оноо авсан суралцагч 0%-тай, 3 оноо авсан суралцагч 27%, 2 оноо авсан суралцагч 8%, 1 оноо авсан суралцагч 14%, 0 оноо авсан нь 19%-ийг тус тус эзэлж байна. Энэ үр дүн оюутнуудын сэтгэхүйн үйл харьцангуй метафорчлагдсан (32%) байгааг илэрхийлж байна. Нөгөө талаас метафорын талаарх ойлголтгүй хэдий ч үндэсний сэтгэлгээний онцлог шууд бусаар илрэх хандлагатай (14%, огт ойлголтгүй 19%) байгаа нь оюутнууд эх хэлний суурь мэдлэг хангалтгүй байгаагаар холбоотой. Иймд багш нар гадаад хэлний заах арга зүйд үндэсний соёлын менталитийг хөгжүүлэх аргыг ашиглах шаардлага гарч байгаа юм.



### Туршилт судалгаа

Туршилт судалгааг оюутны танин мэдэхүйн чадварт тулгуурлан өвөрмөц хэлц нь үгийн утга шилжиж өөр нэгэн ухахуун, утга санааг илэрхийлэх ба тухайн ард түмний сэтгэлгээ



нэвт шингэсэн, нийлэмж үг юм гэсэн ойлголтыг өгсөнөөр оюутан өвөрмөц хэлцийг үйл үг, хэлц үйл үгээс ялган таних чадвар (65%) өссөн байна.

Хэл шинжлэлийн үүднээс өвөрмөц хэлцийн талаар ерөнхий ойлголт өгөөгүй тохиолдолд түүнийг үгсийн сангийн утгын хувьд хольж будилах нь энгийн үзэгдэл юм.


Туршилт судалгааны 2-р даалгаварт гадаад хэл заах (сонсох ба хэл ярианы, харааны төсөөллийн, биеийн хөдөлгөөн, оролцоонд суурилсан) аргуудыг ашиглан оюутнуудад зүйрлэлүүдийг тохируулах хэлбэрээр (Pigs get fat, hogs get slaughtered -Шунал ихэдвэл шулам болно, Fat cat-нударган баян) өгч метафорыг

(зүйрлэл) хэрхэн ойлгож байгааг авч үзэв. Үүнээс үзэхэд туршилт хичээлд оролцсон нийт оюутнуудын 3% хангалтгүй үнэлгээ авсан нь тэдний үндэсний соёлын суурь үнэлэмж

/мэдлэг/ дутмаг мөн тухайн ухахууныг хэрхэн хүлээн авч байгаа хийсвэрлэн сэтгэхүйн хурд харилцан адилгүй байгааг илэрхийлж байна.

Нөгөөтэйгүүр оюутнуудын 97% нь метафор утгыг эх хэл, үндэсний сэтгэлгээний онцлогт тулгуурлан таньж мэдэснээр төрөл бус хэлний ижил ба ялгаатай талыг таньж ойлгох, улмаар хэрэглээнд оруулах чадвар төлөвших хандлагатай байгааг илтгэж байна.


Оюутны танин мэдэхүйн чадварт тулгуурлан зорилтот буюу англи хэлний өвөрмөц



хэлцийг тогтоох, бодит харилцаанд хэрэглэхэд тухайн хүний ерөнхий суурь мэдлэг болоод зорилтот болон төрөлх хэл, соёлын шүтэлцээт байдалтай салшгүй холбоотой байна.

Зураг 5-аар туршилт хичээлд оролцсон оюутнуудын 92% нь метафорыг ойлгож хэрэглэхэд а) сонсох ба хэл ярианы арга (audio-lingual method), б) харааны төсөөллийн арга, в) биеийн хөдөлгөөн, оролцоонд суурилсан (kinesthetic) аргуудыг илүү үр дүнтэй гэж үзсэн бол 8% нь сэтгэхүйн хурд удаан, сурахуйн үйлд хандах хандлага сул, ерөнхий суурь мэдлэг хангалтгүй байна.

Туршилт судалгаанд сургалтын сонсох ба хэл ярианы арга (audio-lingual method), харааны төсөөллийн арга (visual method), биеийн хөдөлгөөн, оролцоонд суурилсан (kinesthetic) аргуудыг хослуулан ашигласан нь үр дүнтэйн дээр харааны төсөөллийн (visual method) арга нь метафорыг ойлгоход арай дөхөм нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тиймээс багш нар зорилтот хэл, соёлын салшгүй уялдааг тусгасан сургалтын арга, технологийг сургалтанд бүтээлчээр ашиглах мэргэжлийн хариуцлага хүлээхийн зэрэгцээ багшийн хөгжлийн асуудлууд ч хамтдаа шийдэгдэх онцлогтой юм.



### 3. ДҮГНЭЛТ

Гадаад хэл сурахад оюутнаас сэтгэхүйн хурд, хүлээж авах чадварын төлөвшил шаардаж байдгийг судалгааны үр дүн харуулж байна.

Үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс зорилтот хэлийг сурахад үндэсний соёлын үнэлэмжийн жишиг хэмжүүр /эталон/-ийг харгалзах нь сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, оюутны сурах идэвхийг сайжруулах давуу талтай болохыг тандалт болон туршилт судалгааны дүнгээс харж байна.

Мэргэжлийн англи хэлний хичээлийг заахад тааралддаг метафорыг хэл соёлын шүтэлцээнд тулгуурлан сургалтын холимог арга, технологийг ашиглах нь оюутны гадаад хэл сурах бодит хэрэгцээг хангахад зохих нөлөө үзүүлэх нь бидний туршилт хичээлээр батлагдлаа.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

#### I. Монгол хэлээр хэвлэгдсэн бүтээл

Б.Сумъяа. (1998). Нүүдэлчид ба соёл. In Б.Сумъяа, *Монголын нүүдэлчдийн соёл* 101-106х Улаанбаатар хот: Адмон ХХК.

Ж.Баянсан. (2002). *Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ*. Улаанбаатар.

Ц.Магсар. (2016). Цаг үе ба метафорчилах сэтгэлгээ.

Ц.Оюунцэцэг, Ж. (2016). Гадаад хэл соёл, даяарчлал. *Гадаад хэл заах арга зүйн асуудал*, 47-49х

Ц.Оюунчимэг. (2012). *Их, Дээд сургуулийн заах арга зүйн ухаан*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.

#### II. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээл

Byram, M. (1988). *Cultural Studies in Foreign Language Education*. The University of Michigan: Multilingual Matters.

Carroll, J. B. (1958). *Language, thought and Reality: Selected Writings of Benjamin Lee Worf*. Massachusetts: MIT Press.

Kramsch, C. (1995). Context and Culture in Language Teaching. *Applied Linguistics, Volume 16, Issue 2*, 264-267.

Lackoff, G. (2002). *Metaphors we live by*. The University of Chicago Press.

В.А.Маслова. (2007). Введение в когнитивную лингвистику. Москва.



**AN APPLICATION OF LANGUAGE LEARNING STRATEGIES OF HIGH SCHOOL STUDENTS IN  
MONGOLIA**

**Zolzaya Otgonkhoo<sup>1,a</sup>**

<sup>1</sup> Applied Linguistics Department, Foreign Language Institute, MUST, Mongolia

<sup>a</sup> zolzayaz@must.edu.mn

**Abstract**

*The study observes the current language learning strategies employed by Mongolian high school students. It aims at surveying the relationship between favored language strategies, gender, and grades. For this purpose, a questionnaire was administered to 896 participants of public schools urban and rural areas of Mongolia. Although, the results of the study indicated that the participants were medium users of language learning strategies, metacognitive strategies (the mean ranked 3.42) were the most frequently used and memory strategies (the mean ranked 2.96) were the least used. The results also showed that the significant differences exist between male and female students.*

**Keywords:** language learning, strategy category, high school students, correlation

## **INTRODUCTION**

With the development of the research on second language acquisition, more and more attention has been paid to the research on individual learner differences. Among those, language learning strategies have been increasingly attracting the interest of contemporary educators as they have potential to enhance learning. Learning strategies are required to have the principal influence on the rate and level of second language acquisition (Ellis, 1994; Oxford, 1990). Over the years, many researchers have studied and examined the language learning strategies. However, the results of the studies are different and controversial. Most of the research subjects in these studies are students in different colleges and universities. There is little in the literature that focuses on the language learning strategies of students learning English in secondary and high schools.

The following research questions are addressed in this study:

1. What is the general pattern of language learning strategies by secondary and high school students in Mongolia?
2. Are there any differences between male and female students in using language learning strategies?
3. Are there any differences in strategy using language learning strategies in terms of students' grades?

## **1. THEORETICAL FRAMEWORK**

### **1.1 Definition and classification of language learning strategies**

Since the mid-seventies, more and more researchers and teachers in ESL field have realized the importance of the strategies used by learners in the language learning process (O'Malley & Chamot, 1990; Zhou, 2010). But as for the definition and classification of the language learning strategies, researchers have different opinions. Robin (1975:43) defined the learning strategies as 'the techniques or devices that a learner may use to acquire knowledge'. In her later research, she identified two kinds of learning strategies: those that contribute directly to learning, and those that contribute indirectly to learning. The direct learning strategies include clarification/verification, monitoring, memorization, guessing/inductive inferencing, deductive reasoning, and practice. The indirect learning strategies are creating opportunities for practice

and production tricks. Stern, in 1975, also produced a list of ten language learning strategies which he believed to be characteristic of good language learners.

Later, Stern (1992:261) defined 'strategies' as 'broadly conceived intentional directions'. O'Malley et al (1985:23) identified learning strategies as being 'operations or steps used by a learner that will facilitate the acquisition, storage, retrieval or use of information', which was originally used by Rigney (1978). They identified 26 strategies, which can be divided into three categories: metacognitive (knowing about learning), cognitive (specific to distinct learning activities) and social. Oxford (1990:8) also used Rigney's definition, described language learning strategies as 'operations employed by the learner to aid the acquisition, storage, retrieval or use of information'. However, she classified learning strategies into six groups: memory strategies (e.g., grouping, representing sounds in memory), cognitive strategies (e.g., repeating, analyzing, getting the idea quickly and taking notes), compensation strategies (e.g., switching to the mother tongue, using other clues), metacognitive strategies (e.g., linking new information with already known one, self-monitoring), affective strategies (lowering anxiety by use of music, encouraging oneself and discussing feelings with others), and social strategies (asking for clarification, cooperating with others and developing cultural understanding). These six groups in the later studies were further divided into direct strategies and indirect strategies. From the above, we can see that there is no consensus on the definition and classification of language learning strategies in the field of language learning strategy research.

Apart from language proficiency, as research has shown, there are other factors that exert influence on the strategies that the language learners select and use. For instance, gender was one factor that has been explored by a number of researchers. In language learning strategy studies involving gender, efforts have been made to investigate the strategies used by males and females and 'the sex difference findings to date show that in typical language learning situations females use significantly more learning strategies than males and use them more often' (Oxford 1989, p.239).

## **1.2 Research into language learning strategies**

Early learning strategy research was mostly about listing and classifying language learners' strategy use, especially strategies used by good language learners (Robin, 1975; Stern, 1975). Later on, researchers attempted to investigate the relationship between language learning strategies and success in language development, strategy use and language proficiency. Green and Oxford (1995) found that language learning strategies of all kinds were used more frequently by higher level students. Griffiths (2003) also discovered a positive correlation between course level and reports frequency of language learning strategy use. Park (1997) revealed a positive linear relationship between strategy use and language proficiency.

Many studies have also done to investigate the factors affecting strategy choice or strategy use. A great deal of evidence has been found on the gender differences in the use of language learning strategies. Ehrman and Oxford (1989), Oxford and Nyikos (1989) and Green and Oxford (1995) discovered distinct gender differences in strategy use. The results showed that females were more frequent users of strategies. But in Ehrman and Oxford's another study done in 1990, they failed to discover any evidence of differing language learning strategy use between the sexes. The result of the study done by Li (2002) also showed that there was no significant difference between the employment of learning strategies and the students' gender in foreign language learning.

Another branch of studies done in the language learning strategy field is about the effects of strategy training. Many researchers have worked to apply the findings from previous studies into the pedagogical practice and come to the conclusions that language learning strategies are teachable and that learners can benefit from training in learning strategies (Cook, 1991; Larsen-Freeman, 1991; Oxford, 1990).

From the above literature review, we can see researchers differ in defining and classifying language learning strategies and that many studies have been done on language learning strategies. Although the results are different and controversial, the hypothesis that good language learners' success may be due to the use of more effective language learning strategies and the assumption that language learning strategies may be taught and trained to improve the learners' learning are appealing and worth being studied further.

## **2. METHODOLOGY**

### **2.1 Participants**

A sample of 896 respondents participated in this study but one student did not complete the questionnaire, comprised of 482 females (53.8%) and 414 males (46.2%) between the grades of 6 to 12 and randomly selected from five public high schools in urban and rural areas of Mongolia. Permission to participate in the study was obtained from their teachers and participants were told to do the questionnaire carefully and objectively.

### **2.2 Instruments**

In order to collect information on strategy use, Oxford's (1990) Strategy Inventory for Language (SILL, version 7.0) was adapted for the study. The SILL was developed by Rebecca Oxford (1990) as an instrument for assessing the frequency of use of language strategies by students. It appears that SILL is the 'most often used strategy scale around the world', and the only language learning strategy instrument that has been checked for reliability and validated in multiple ways (Oxford & Burry-Stock, 1995). SILL is 'perhaps the most comprehensive classification of learning strategies' (Ellis, 1994) and 'has been widely employed by researchers all over the world' (Lim 2002). SILL 'has been employed as a key instrument in numerous studies' (Hong-Nam and Leavell, 2006).

The SILL used in the current study consists of 50 items and has been classified into 6 categories: (a) memory strategy items (items 1 to 9), (b) cognitive strategy items (items 10 to 23), (c) compensation strategy items (items 24 to 29), (d) metacognitive strategy items (items 30 to 38), (e) affective strategy items (items 39 to 44), and (f) social strategy items (items 45 to 50). They are assessed on a five-point Likert scale ranging from 1 to 5. The number indicates the frequency of strategy use, ranging from 1 (never or almost never) to 5 (always or almost always).

### **2.3. Procedures and Data Analysis**

The questionnaires were given to the participants by their teachers in English classes. The participants were informed of the purpose of the questionnaire and of the fact that there was no right or wrong answer. They were also asked to express their honest options according to their own specific conditions by making the appropriate choice on the right side of each statement. The participants were able to complete the survey in about 20 minutes. Each completed

questionnaire was manually examined, and 896 questionnaires were usable and used for statistical analysis but 1 questionnaire was not usable.

The data from the SILL questionnaire sheets were analyzed with SPSS 18.0 to measure the learning strategy use. Descriptive statistics provided the means and standard deviations (SD) to analyze the participants' general pattern of language learning strategy use and the strategies frequently used and less frequently used. Independent sample tests were used to analyze the differences between male and female participants and among the seven grades. Correlation analysis was conducted to examine the relationship between learning strategy use and gender.

### 3. RESULTS

#### 3.1 The general pattern of language learning strategy use

In order to assess the general pattern of language learning strategy use, the study calculated the mean and standard deviation of the six SILL categories respectively. As Oxford also divided learning strategies into two main groups: direct strategies (memory, cognitive and compensation strategies) and indirect strategies (metacognitive, affective and social strategies), we also calculated the descriptive statistics of the direct and indirect strategy groups. The details of the statistics were presented in Table 1.

Table1. Descriptive Statistics for all learning categories

Categories	Mean	Deviation	Std.
Memory	2.96	0.74	
Cognitive	3.11	0.76	
Compensation	3.06	0.84	
Metacognitive	3.42	0.83	
Affective	3.12	0.85	
Social	3.17	0.89	
Direct	3.05	0.69	
Indirect	3.26	0.75	

In the study, generally speaking, students in secondary and high schools used indirect strategies more than direct strategies. According to Oxford's (1990) division of language learning strategy use (High usage is from 3.5 to 5.0; Medium usage is from 2.5 to 3.4; and Low usage is from 1.0 to 2.4), these participants used learning strategies at a medium level because the mean of the total was medium. The means of each category, which ranged from 2.96 to 3.42, also indicated that these students were medium users of language learning strategies. From Table 1, it could also be seen that, among six categories, secondary and high school students used metacognitive strategies most frequently and memory strategies least frequently. From this study, we can get the general pattern of language learning strategy use by these secondary and high school students in Mongolia, which is metacognitive, social, affective, cognitive, compensation and memory.

#### 3.2 The gender differences in language learning strategy use

As shown in Table 2, the means of six categories ranged from a high one of 3.59 to a low one of 3.06 for females and from a high one of 3.22 to a low one of 2.85 for *males*. For male students, none of the 6 categories was in the high usage group, while for females there was 1 category which belonged to the high usage group. This table also indicated that both males and females used metacognitive strategies most frequently and memory strategies least frequently. According to means of the total, it could be concluded that females used strategies more than males. This result was consistent with the findings of Green & Oxford (1995), in which females used significantly more learning strategies than males.

Table 2. Differences in learning strategy use between males and females

Categories	Male (N=414)		Female (N=482)	
	Mean	Std. Deviation	Mean	Std. Deviation
Memory	2.85	.79	3.06	.67
Cognitive	2.99	.76	3.22	.74
Compensation	2.91	.82	3.18	.83
Metacognitive	3.22	.83	3.59	.79
Affective	2.96	.89	3.25	.79
Social	3.01	.88	3.30	.88
Total	2.99	.83	3.27	.78

Table 3 below showed the correlation between gender and learning strategy use. Gender was highly correlated with metacognitive, affective, social, compensation, cognitive and memory strategies [Sig. (2-tailed) <0.01].

Table 3. Correlation between gender and language learning strategy use

	Gender
Memory	.143**
Cognitive	.152**
Compensation	.157**
Metacognitive	.224**
Affective	.169**
Social	.162**

\*\* . Correlation is highly significant at the 0.01 level (2-tailed).

\* . Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

### 3.3 The differences among the students in seven grades

The study revealed that students in all seven grades were medium users of learning strategies, with 6<sup>th</sup> grade using strategies more (Total M=3.41) and 12<sup>th</sup> grade students using strategies least (Total N=2.90). Table 4 in this study indicated that generally the means of each category descended as grade went up with exception of metacognitive, cognitive, memory and compensation strategies that rose slightly among the students in 8<sup>th</sup> grade. Moreover, in metacognitive strategy use, students in 6<sup>th</sup> grade had the highest mean while students in 12<sup>th</sup> grade had the lowest mean.

Table 4. Descriptive statistics of learning strategies by 7 grades

	6th grade (N=118)		7th grade (N=77)		8th grade (N=112)		9th grade (N=78)		10th grade (N=179)		11th grade (N=260)		12th grade (N=72)	
Memory	3.25	0.75	2.99	0.84	3.18	0.77	2.85	0.71	2.90	0.71	2.80	0.66	2.70	0.74

Cognitive	3.40	0.80	3.17	0.76	3.30	0.71	3.04	0.80	3.05	0.75	3.03	0.70	2.82	0.77
Compensation	3.20	0.90	3.08	0.90	3.14	0.85	2.98	0.91	3.06	0.84	3.04	0.76	2.79	0.80
Metacognitive	3.75	0.83	3.45	0.85	3.53	0.84	3.37	0.93	3.33	0.77	3.34	0.76	3.24	0.89
Affective	3.39	0.88	3.38	1.02	3.16	0.84	3.07	0.84	3.05	0.79	3.01	0.79	2.91	0.80
Social	3.41	0.92	3.32	0.85	3.27	0.87	3.07	0.89	3.17	0.89	3.07	0.87	2.86	0.90
Total		0.85	3.23	0.87	3.26	0.86	3.07	0.88	3.09	0.79	3.06	0.76	2.90	0.82

## 4. DISCUSSION

### 4.1 The overall learning strategy use

The means of six categories are all below 3.5, which indicate that students in secondary and high schools in Mongolia are medium users of language learning strategies. Students prefer using indirect strategies to direct strategies. According to Oxford (1990), good language learners manage their own learning process through metacognitive strategies, control their emotions through affective strategies and collaborate effectively with their peers or teachers by using social strategies. The most frequently used learning strategies are metacognitive strategies (M=3.42), with the particular item “I have clear goals for improving my English skills,” I try to find out how to be a better learner of English” (M=3.60>3.5) at the highest. The result is similar to that of Li (2002). However, one surprising finding of the study was that memory strategies were the least frequently used strategies. The results contradict with that of Li (2002), Oxford (1990) and many other studies conducted in Asia.

### 4.2 The differences between learning strategy use and gender

This study shows that there is a significant correlation between learning strategy use and gender in secondary and high schools. The significant correlations are found in all six categories [Sig. (2-tailed), 0.05]. We can come to conclusion from this study that females in secondary and high schools use metacognitive strategies more frequently than males, such as managing the learning process and deal with the task, e.g. planning, identifying and selecting resources. In secondary and high schools in Mongolia, we can find females generally do better in English than males. This phenomenon may be related to the use of English learning strategies because females use more learning strategies related to English learning than males and females are more active in using learning strategies to get effective learning. Another reason may be that females are more stable than males in attitude and learning motivation, because they are more nature in physical and psychological development. Females are willing to work hard and use learning strategies to improve their learning while males are indulgent in playing.

### 4.3 The relationship between learning strategies use and grades

As for the differences among seven grades, students use learning strategies less frequently as they go into higher grades. This result is somewhat surprising and confusing. In our opinion, as

students become more physically and psychologically mature, they should use learning strategies more often. However, it is not the case in this study. The reason for this may be due to the great pressure of university entrance examination that high school students face.

## CONCLUSION

This study aimed to find out the general pattern of language learning strategy use by secondary and high school students and the differences in gender and grades in Mongolian context. It revealed Mongolian secondary and high school students use metacognitive strategies most and memory strategies least. Female students use strategies more than male students. As for the differences in grades, the higher grade the students are in, the less frequently they use learning strategies. As researches and studies in the field of language learning strategies show us, learning strategy use is closely related to the students' academic performance and teachers can assist the language learning process by promoting language learning strategy awareness and use. Therefore, teachers in secondary and high schools should pay special attention to the use of language learning strategies among students and train them to use strategies that are beneficial for them on the basis of the differences in their characters. Only by combining strategy instruction with the teaching content appropriately can teachers achieve satisfactory teaching results.

## REFERENCES

1. Ellis Rod, (1994). A Theory of Instructed Second Language Acquisition. In N. Ellis (Ed.), *Implicit and Explicit Learning of Languages*. Academic Press.
2. Oxford, R.L. (1989). *Language Learning Strategies: What Every Teacher Should Know*. New York: Newbury House Publishers.
3. O'Malley, J.M. & Chamot, A.U. (1990). *Learning Strategies in Second Language Acquisition*. Cambridge: Cambridge University Press.  
<http://catdir.loc.gov/catdir/samples/cam031/89009770.pdf>
4. Zhou Yaping, (2010). English Language Learning Strategy Use by Chinese Senior High School Students
5. Robin, J. (1975). What the 'good language learner' can teach us. *TESOL Quarterly*, 9(1), 41-51  
[https://www.academia.edu/1195701/What\\_the\\_good\\_language\\_learner\\_can\\_teach\\_us](https://www.academia.edu/1195701/What_the_good_language_learner_can_teach_us)
6. Stern H.H. (1975) What Can We Learn from the Good Language Learner? *Canadian Modern Language Review*, 31, 304-318.
7. O'Malley J. M, (1985). Language Learning: Learning Languages Used by Beginning and Intermediate ESL Students. *A Journal of Research in Language Studies*, Volume 35, Issue 1. March 1985, Pages 21-46.
8. Rigney, JW. (1975) *Learning Strategies: A Theoretical Perspective*. In H.F. O'Neil, *Learning Strategies* New York: Academic Press.
9. Oxford, R. L (1990). *Language Learning Strategies: What Every Teacher Should Know*. Newbury House.



10. Green, (1995). A Closer Look at Learning, L2 Proficiency and Gender. John M. Green – Salem State College, Rebecca Oxford – University of Alabama. TESOL QUARTERLY Vol. 29, No. 2, Summer 1995.
11. Griffiths, C. (2004) Language Learning Strategies: Theory and Research. *School of Foundation Studies*. [http://www.crie.org.nz/research-papers/c\\_griffiths\\_op1.pdf](http://www.crie.org.nz/research-papers/c_griffiths_op1.pdf)
12. Park, Gi-Pyo. (1997) Relationship Between Listening, Strategy Use and Listening Ability.
13. Ehrman, M. & Oxford, R. (1990). Adult language learning styles and strategies in an intensive training setting. *The Modern Language Journal*, 74(3), 311-327  
[https://www.academia.edu/2344095/Adult\\_language\\_learning\\_styles\\_and\\_strategies\\_in\\_an\\_intensive\\_training\\_setting](https://www.academia.edu/2344095/Adult_language_learning_styles_and_strategies_in_an_intensive_training_setting)
14. Oxford, R. L., Martha Nyikos (1989). *The Modern Language Journal: Variables Affecting Choice of Language Learning Strategies by University Students*. Volume 73, Issue 3. Autumn 1986, Pages 291-300.
15. Li Jongying (2002) An Empirical Study on Learning Strategies of Chinese ESL Learners, Li Jongying *Foreign Language Education – 2002-1*
16. Cook, V. (2008). *Second Language Learning and Language Teaching*. London: Hodder education
17. Larsen-Freeman, D, (1991). Second language acquisition research: staking out the territory. *TESOL Quarterly*, 25(2), 315-350 <http://eprints.cdlib.org/uc/item/3165s95t>
